

БАТЛАВ:

ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ

БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ГАЗРЫН ДАРГА _____ Г.ЭНХМӨНХ

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

МОН-ФРУКТ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ _____ Э.ТАМИР

**МОНФРУКТ ХХК НИЙ УЛААНБААТАР ХОТ СОНГИНОХАЙРХАН
ДҮҮРГИЙН 33-Р ХОРООНЫ НУТАГТ ОРШИХ БАРУУНТУРУУН-2
ОРД (БАЯЖУУЛАХ, БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР)-ЫН 2026 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР МV-016848/

ХЯНАСАН:

ХБОБЗГ-ЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ

БОЛОВСРУУЛСАН:

МОН-ФРУКТ ХХК БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН _____ Д.МӨНХЗУЛ

2026 он

АГУУЛГА

1.ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
2. БАРУУН ТУРУУН-2 БАРИЛГЫН ЧУЛУУНЫ ОРД ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ.....	4
3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	5
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН	6
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	6
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	7
6. НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭ	14
7.БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	15
8.НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	16
9.ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	16
10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	17
11. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	22
12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭИЙ ХӨТӨЛБӨР	31
14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	33
15. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ.....	34
16. ХАВСРАЛТУУД.....	37

ҮНДЭСЛЭЛ

Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1, 2-р хэсэг, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А-618 дугаар бүхий тушаалаар баталсан шинэчилсэн журмын дагуу “Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг” боловсруулан гүйцэтгэлээ.

Баруун туруун-2 барилгын чулууны ордыг ашиглах төслийн үйл ажиллагаа нь газрын хэвлийтэй харьцан түүний баялгийг ашиглахдаа байгалийн өнөөгийн төрхийг хамгаалах, агаар, ус, хөрс, ан амьтан, ургамал болон хүн амд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг тогтоож, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулан Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай, Ашигт малтмалын тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиуд, Засгийн газрын холбогдох тогтоолууд, Байгаль орчны яамнаас гаргасан журам, зааврууд, Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, тодотгол зэргийг үндэслэн орд ашиглах төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсрууллаа.

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Орд байрлах MV-016848 ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй талбай нь засаг захиргааны хувьд Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн нутагт харьяалагдана. Топопланшет L-48-10.

Тусгай зөвшөөрлийн талбайн газарзүйн солбицлыг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 1-1. Тусгай зөвшөөрлийн талбайн газарзүйн солбицол

Тусгай зөвшөөрлийн дугаар	Цэгийн дугаар	Солбицолуудын цэгүүд	
		Уртраг	Өргөрөг
MV-016848	1	106° 37' 45"	47° 56' 36"
	2	106° 38' 40"	47° 56' 36"
	3	106° 38' 40"	47° 55' 59"
	4	106° 37' 45"	47° 55' 59"



Зураг 1-1. Төслийн талбайн байршил /google earth/

УБ хотын баруун захаас орд хүртэл 22 км, хотын төвөөс орд хүртэл 30 км байна.

2. БАРУУН ТУРУУН-2 БАРИЛГЫН ЧУЛУУНЫ ОРД ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Уул зүй: Район нь Хэнтийн уулархаг мужийн баруун урд хэсэгт харьяалагдана. Талбайн туйлын өндөржилт талбайн хэсэгт 1431 м, Улаанбаатар хотын дүүрэгт 1335м байна. Районы өндөр цэгийн хэлбэлзлийн амплитуд нь 1100 м-т хүрнэ.

Ус зүй: Ордын районд зөвхөн Туул гол урсан өнгөрөх ба олон тооны жижиг цутгалангуудтай. Туул гол нь Монгол орны том голын нэг юм. Туул гол Бага Хэнтий нурууны өмнөд хажуугаас эх авч урсан Орхон голтой нийлж, Сэлэнгэ мөрөнд цутгадаг. Туул голын усны зардал маш тогтворгүй, зун борооны үед түүний түвшингийн хоногийн хэлбэлзэл 50-60 см-ээр дээшилдэг. Туул голын усны урсгалын хурд 1.2 м/сек, голын усны өргөн 30-70 м, гүн нь 0.8-3.5м, олон жилийн ажиглалтын мэдээгээр голын усны урсацыг 101.0 м³/сек гэж тогтоосон бөгөөд голын усны хамгийн их урсацыг Сонгино уулын орчимд 470 м³/сек гэж тодорхойлжээ.

Байгаль, цаг уурын нөхцөл: Ордын район нь эх газрын эрс тэс уур амьсгалтай. Улирлын болон хоногийн температур нь эрс тэс хэлбэлзэлтэй, хур тунадасны хэмжээ 193.4-297.4мм хооронд хэлбэлзэх бөгөөд жилийн дундаж нь 220мм байна. Анхны цас 9-р сарын сүүлийн хагасаас, сүүлчийн цас 5-р сарын дунд үед ордог. Жилийн 4 улиралд хур тунадас орох өдрүүдийн тоо харилцан адилгүй. Хамгийн халуун нь 7-р сар, хамгийн хүйтэн нь 1-р сар. Хамгийн их хур тунадас унадаг улирал зун, хамгийн бага унадаг улирал нь өвөл юм. Өвөл хөрс нь 3-4 м гүн хөлддөг.

Дэд бүтэц: MV-016848 ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй талбай нь засаг захиргааны хувьд Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэг, Тахилтын эцэс буюу 33-р хорооны нутаг дэвсгэрт харьяалагдана. Топопланшет L-48-10. Тус орд нь зам харилцааны хувьд харьцангуй сайн, Улаанбаатар хоттой автозам болон ердийн шороон замаар холбогдсон, жилийн аль ч улиралд зорчиход тааламжтай.

3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

1. Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Тэсэлгээний зориулалттай хийгдэх цохилтот өрөмдлөгийн ажлын үед дотоод шаталтат хөдөлгүүрээс гарах утаа тортог, уулын цул тээвэрлэлтийн үед ачих, буулгахад гарах тоос, тэсэлгээний цооногууд өрөмдөх үед гарах тоос, хүчтэй салхитай үед овоолгуудын гадаргуугаас гарах тоос нь агаар орчинд хэсэгчилсэн бохирдолтыг бий болгох эрсдэлтэй бөгөөд ашиглалтын ажлын явцад агаарт тоосжилт үүсэх.

2. Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Түлш шатахуун, шатах тослох материалууд асгарах зэргээс үүдэн газрын болон газрын доорх ус бохирдох эрсдэлтэй. Ахуйн хатуу болон шингэн хог хаягдлын асуудлаа зөв менежментын дагуу явуулаагүйгээс болж газрын гадарга болон гүний ус биологийн болон тос тослох материалын бохирдолд орох эрсдэлтэй учир технологийн горимийг чанд мөрдөж ажиллах шаардлагатай.

3. Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Барилгын чулууны ордыг ашиглах төслийн ажлаар өрөмдлөгийн ажил хийгдэх үед газрын гадаргын төрх байдал алдагдаж, хөрсөн бүрхэвч доройтож, ургамлан нөмрөг хөрсөнд дарагдах зэргээр өөрчлөлт орох магадлалтай.

Төслийн нутаг дэвсгэр болон түүний эргэн тойрны нутаг дэвсгэр дэхь тээврийн хэрэгсэл, хүмүүсийн хөдөлгөөний ихсэлттэй холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэн доройтох, ургамлан нөмрөг тоосонд дарагдаж тачир сийрэг болж бүрхэц багасах мөн газрын гадарга болон хөрс ахуйн хаягдал, шатах тослох материалаар бохирдож болзошгүй.

4. Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах техник тоног төхөөрөмжөөс гарах дуу чимээнээс болж хөхтөн, шувуу, жижиг мэрэгч амьтдууд дайжиж алга болох, мөн хөрс хуулалтын үйл ажиллагаанаас хөрсөн дэх макро, микро бичил амьтад үхэж хорогдох зэрэг нөлөөллүүд үүсч болно.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Энэ онд хийгдэх ажлын явцад байгаль орчинд нөлөөлөх сөрөг үр дагавар үүсэхээс урьдчилан сэргийлэх, байгалийн унаган төрхийг эвдэхгүй байх, Дүүрэг хорооны иргэдтэй хамтран ажиллах, ургамал, хөрс, усан орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх арга хэмжээний төслийг боловсруулан даган мөрдөж ажиллахад оршино. Ашиглалтын ажлын явцад тоосжилт, шинэ зам гарах, хог хаягдлын зохистой хадгалалт, устгалын тухай менежментыг дадал болгох жилээс жилд сайжруулан ажиллах зорилготой байна.

Дээр дурдсан болзошгүй гол сөрөг нөлөөллийг бууруулах болон бусад байгаль хамгаалах удирдлагын, менежментийн арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай юм. Болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмжийг нөлөөлөлд өртөж болзошгүй бүрэлдэхүүн тус бүрээр нь ангилан тодорхойлж доорхи хүснэгтэнд харуулав.

**БАРУУН ТУРУУН-2 БАРИЛЫН ЧУЛУУНЫ ОРД ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ АЖЛЫН
ТӨЛӨВЛӨГӨӨ /хүснэгтээр/**

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаарын чанар									
1.	Машин техникийн хөдөлгөөнөөр орчны тоосжилт нэмэгдэх	Технологийн дотоод зам дагуу усалгаа хийж, тоосжилтыг бууруулах.	Машин техник зорчих дотоод зам	м	ҮА-ны зардал	208	ҮА-ны зардал	Ашиглалтын үед байнга	Агаарын тухай хуулийн 9.1.7
2.	Том оврын тээврийн хэрэгслүүд, машин	Ашиглах техник хэрэгсэл, машин механизмын янданд шүүлтүүр тавих	Машин техник, хөдлөх хэрэгсэл	ш	ҮА-ны зардал	8-10	200,000	Жилд 1-2 удаа	Агаарын тухай хуулийн 9.1.7
3.	меахнизмын хөдөлгүүрээс хорт хий ялгарах	Техникийн үзлэг, оношлогоонд тогтмол хамруулж, завсар үйлчилгээг хийж байх	Машин техник	ш	ҮА-ны зардал	8-10	ҮА-ны зардал	Оношилгоонд жил бүр оруулах, Засвар үйлчилгээг тогтмол хийх	Агаарын тухай хуулийн 9.1.2
4.	Бүтээгдэхүүн тээвэрлэлтийн үед орчинд тоосжилт үүсэх	Уулын цул, барилгын чулууг тээвэрлэхдээ хучилтын арга хэмжээг хэрэгжүүлэх /брезент, нийлэг материал г.м/	Бүтээгдэхүүн тээвэрлэлт	ш	ҮА-ны зардал	2	ҮА-ны зардал	Тээвэрлэх бүрт	Агаарын тухай хуулийн 9.1.7

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
5.	Ахуйн хог хаягдлын битүүмжлэл муугаас орчинд тархаж, ялзарч муудах, орчинд таагүй үнэр тархах	Хог хаягдалын менежментийн төлөвлөгөөний дагуу гэрээт компанитай байгуулсан гэрээний дагуу улирал тутам хог ачих, халдваргүйжүүлэлт хийх	хаягдлын цэг, соруулдаг кольцоо бүхий эко жорлон	-	110'000	2	220,000	Жил бүрийн дулааны улиралд 2 удаа	MNS 5161-3:2002
6.	Уурхайн үйл ажиллагаа, машин техникийн хөдөлгөөнөөр тухайн орчны агаарын чанарт нөлөө үзүүлэх	Агаарын чанарын хяналт шинжилгээг тогтмол хэрэгжүүлэх	Уурхайн бүсийн тоосжилт, агаар бохирдуулагч хий	Мг/м3	ОХШХ-т тусгагдсан	-	ОХШХ-т тусгагдсан	Жил бүр ОХШХ-т тусгагдсаны дагуу	Агаарын тухай хуулийн 9.1.4 MNS 4585:2016
Гадаргын ба газрын доорхи усны нөөц									
7.	Усны нөөцийг зөвшөөрөлгүй, хэтрүүлэн ашиглах	Ус ашиглалтын цооногийн усыг шинжилгээнд хамруулах,	Ус ашиглалтын цооног	-	60,000	3	180'000	улиралд 1 удаа	Усны тухай хуулийн 27.3, 32.10
8.		Ус ашиглалтын цооногт суурилуулсан тоолуурыг тогтмол баталгаажуулалтад хамруулах	Ус ашиглалтын цооног	-	ҮА-ны зардал	-	ҮА-ны зардал	Олборлолт эхлэхийн өмнө тоолууржуулах, баталгаажуулалтыг гэрчилгээнд	Усны тухай хуулийн 30.1.4

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
								заасан хугацаанд	
9.		Ус ашиглах зөвшөөрөл авах, гэрээ байгуулах,	Ус ашиглалт	Мян.м3	500,000	-	400,000	Жил бүр	Усны тухай хуулийн 28.4, 28.6, 291.1, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 6-р зүйл
10.	Ажилчдын ундны усны чанар, аюулгүй байдал алдагдах	Ажилчдын ундны усыг хүнсний зориулалттай саванд нөөцлөн ашиглах эсвэл гал тогоо руу орох хоолойд шүүлтүүр суурилуулах	Ундны ус	-	ҮА-ны зардал	-	ҮА-ны зардал	Байнга	MNS ISO TS 22002-4:2020 MNS 0900:2018
11.	Бохир усыг тогтмол хугацаанд зайлуулаагүйгээс хөрс бохирдох, хөрсний үе давхаргаар шингэн газрын	Ажилчдын ахуйн хэрэглээ, угаалга цэвэрлэгээнээс гарах хаягдал усыг бага оврын цэвэрлэх байгууламж суурилуулж, цэвэрлэх,	Бохир ус	м3	ҮА-ны зардал	-	ҮА-ны зардал	2025 онд суурилуулах	MNS 4943:2015 MNS 6734:2018

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	доорх усны чанарт нөлөөлөх	тоос дарах усалгаанд ашигладаг болох							
Хөрсөн бүрхэвч									
12.	ШТМ асгаран хөрс бохирдох, завсар үйлчилгээний хаягдал ил задгай хаягдах	Машин техникийн засвар үйлчилгээ хийх талбайг тогтоож, нэг цэгт төвлөрүүлэн гүйцэтгэх, засварын газрын цементлэж ШТМ асгарч хөрс, хөрсний усанд нэвчихээс хамгаалах	Машин техникийн засвар үйлчилгээний цэг	Байршил	ҮА-ны зардал	1	ҮА-ны зардал	Олборлолт эхлэхийн өмнө талбайг бэлтгэнэ	Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.1
13.	Төслийн явцад хөрс ахуйн ба үйлдвэрлэлийн хог хаягдлаар бохирдох	Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг ангилан ялгах зориулалттай, түр цэг байгуулах	Хог хаягдал	Ангилах цэг	Хог хаягдлын менежментийн зардал	6-7	Хог хаягдлын менежментийн зардал	Олборлолт эхлэхийн өмнө	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.1, 10.2.2, 10.2.8,
14.	Машин техникийн хөдөлгөөнөөр олон салаа зам гарч хөрс эвдрэх	төхөөрөмжүүдийн талбайд орох, гарах маршрутыг нарийвчлан тогтоох, тэмдэглэгээ байршуулах, тэмдэгжүүлэн, цаашид хяналт тавих	Орох гарах болон дотоод зам	км	ҮА-ны зардал	-	ҮА-ны зардал	Замын маршрутыг олборлолт эхлэхийн өмнө тодорхой болгох,	Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 6.1.6

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
15.	Машин техникийн бүрэн бус байдал, анхаарал болгоомжгүй байдлаар ШТМ асгарч хөрс бохирдуулах, нэвчих	ШТМ асгарч алдагдсан тохиолдолд эхний ээлжинд дээр нь хужир асган шингээж тэр хэсгийн хөрсийг хусаж авах, хор нөлөөгүй болгох, нөхөн сэргээх ажлыг гүйцэтгэж байх	Машин техникийн ашиглалтын явцад	ш	ҮА-ны зардал	8-10	ҮА-ны зардал	Хэрэв ШТМ асгарсан тохиолдолд	Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.1
16.		Авто зогсоолын талбайг цементлэх, битүү засварын байр барих, тэмдэгжүүлэх	Машин техникийн ашиглалт	Байршил	ҮА-ны зардал	1	ҮА-ны зардал	Олборлолтын явцад	Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.5, MNS 5342:2007
17.		Хөрсний хяналт шинжилгээний ажлыг хэрэгжүүлэх	Лицензийн талбай	Байршил	ОХШХ-т тусгагдсан	-	ОХШХ-т тусгагдсан	Жил бүр ОХШХ-т тусгагдсаны дагуу	MNS 5850:2019 MNS
Ургамлан нөмрөг									
18.	Ургамлын нөмрөгийн зүйлийн бүрдэл хомсдох	Ургамлын мониторингийн судалгаа явуулах	Ашиглалтын талбай	га	ОХШХ-т тусгагдсан	-	ОХШХ-т тусгагдсан	2 жилд 1 удаа	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3.4

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
19.		Шимт хөрсийг хамгаалах пайзжуулах болон хөндөгдөөгүй талбайг эвдэгдэхээс сэргийлэх	Ашиглалтын талбай	га	Нөхөн сэргээлтгүй зардал	-	Үйл ажиллагааны зардлаар хийгдэнэ тусдаа зардал тавигдахгүй	Ашиглалтын талбайд техникийн нөхөн сэргээлт хийгдсэний дараа жилээс эхлэн жил бүр	Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал ¹
20.	Хөрс хуулалтын талбайн хэмжээгээр ургамлан нөмрөг устгах	Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайн шимт хөрсний алдагдлыг бууруулахын тулд гадаргууг 15 см гүнтэй сам тавих	Ашиглалтын талбай	га	Нөхөн сэргээлтгүй зардал	-	Нөхөн сэргээлт хийгдэхгүй	Техникийн нөхөн сэргээлт хийсэн жилээс эхлэн жил бүр	MNS 5918:2008
21.	Машин техникийн хөдөлгөөнөөр олон салаа зам гарч, ургамлан нөмрөг халцрах, нөлөөлөлд өртөх	Ашиглалтын талбайн ургамлан бүрхэвчийг хамгаалах үүднээс олон салаа зам гаргахгүй байх, маршрутын зам	Орох гарах болон дотоод зам	-	ҮА-ны зардал	-	ҮА-ны зардал	Замын маршрутыг олборлолт эхлэхийн өмнө тодорхой болгож, тэмдэгжүүлэн,	Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 6.1.6

¹ БОНХАЖ-ын сайдын 2015 оны А-138 дугаар тушаалын хавсралт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
		гаргах, тэмдэглэгээ байршуулах						цаашид хяналт тавих	
Амьтны аймаг									
22.	Уурхайн талбай, түүний орчинд хогийн цэг дээр амьтан тэжээл хайж ирэх, орогнох, үүрлэх	Ахуйн ба үйлдвэрлэлийн хог хаягдлын цэгийг битүүмжлэл сайтай байгуулах	Ахуйн ба үйлдвэрлэлийн хог хаягдлын цэг	Ангилах цэг	Хог хаягдлын менежментийн зардал	6-7	Хог хаягдлын менежментийн зардал	Олборлолт эхлэх бэлтгэл ажлын хүрээнд	Хог хаягдлын тухай хуулийн 15 дугаар зүйл
23.	Төслийн талбайд мал амьтан орж, машин механизмд дайруулах	Олборлолтын талбайд мал амьтан нэвтрэхээс сэргийлж, байнгын хараа хяналт тавих	Олборлолтын талбай	-	-	-	-	Олборлолт явуулах үед	Амьтны тухай хуулийн 6.1.7
		2026 он					1'000'000		

6. НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭ

Техникийн нөхөн сэргээлт

Баруун туруун-2 барилгын чулууны ордын хүдрийн биет нь хэвтээ уналтай бөгөөд нөөц гүн рүүгээ өсөх боломжтой учир ордыг ашиглах явцад жил болгон нөхөн сэргээлтийн ажил хийх боломжгүй юм. Тус төсөл нь ашиглалтын 5 жилийн 3 дах жилээс талбайдаа техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг хийж эхлэх юм.

Биологийн нөхөн сэргээлт

Баруун туруун-2 барилгын чулууны ордын төсөл нь ашиглалтын 5 жилийн 3 дах жилээс талбайдаа техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг хийж эхлэх бөгөөд эхний 2 жилд ажилчдын кемпийн баруун талаар ойн зурвас байгуулахаар төлөвлөж байна. Тиймээс уурхайн кемпийн баруун талаар 1 га талбайд хайлаас мод тарихаар төлөвлөн ажиллаж байна.

Хүснэгт 2

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	Биологийн нөхөн сэргээлт хийгдэхгүй тул тусгай хамгаалалтад шинээр авсан талбайг хамгаалах ажил хийгдэнэ	Хайлаас мод тарих	СХД болон 33-р хороотой зөвшөлцсөний дагуу заагдсан талбайд мод тарьж хашаажуулахад бусад ААН-тэй хамтран оролцоно	500'000 + үйл ажиллагааны зардалд тусгасан	Жилд 2 удаа	“Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал” БОАЖЯам А-138 тушаал
	Нийт зардал			500'000		

7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 3

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	Биологийн олон янз байдлыг сайжруулах зорилтуудыг тогтоох; Биологийн олон янз байдлын менежментийн арга хэмжээг тодорхойлох	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд Нийслэлийн байгаль орчны газраас санал болгосон хэсэг газрын нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэнэ.	Дүйцүүлэх ажлаар булаг шандыг хашаажуулах тохижуулах ажил хийнэ.	дүүрэг орон нутагт	8'000'000	Жилд нэг удаа	БОННУ-ний аргачлал, Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх гарын авлага
		Нийт зардал			8'000'000 төг		

8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Барилгын чулууны орд ашиглах “Баруун туруун-2” тоот тусгай зөвшөөрөлтэй 130 га талбай нь бусдын өвөлжөө, хаваржааны газартай давхцалгүй. Тахилт орчмын гэр хорооллын айл өрхийн суурьшлын бүсээс 1.3 км, лицензийн талбайн баруун талд аж ахуйн зориулалттай хашаа, бараа материалын агуулах зэрэг аж ахуйн нэгжүүд, хатуу хучилттай авто зам 760 м зайтай байна. Эдгээрээс хамгийн ойр зайд /450 м/ Бараа материалын агуулах байрлана. Иймд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлагагүй. Цохилтын аюултай бүс 730 м дотор хүн ам оршин суух суурин газар байхгүй.

9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Ордын талбайн хэмжээнд эртний булш, хадны зураг, түүх дурсгалын хөшөө, туурь зэрэг тэмдэглэгдээгүй, газар тариалан, тусгай хэрэглээний талбайн хэсгүүд, өндөр хүчдэлийн шугам, засмал, төмөр зам, усан сан зэрэг тусгай зориулалтын барилга байгууламж байхгүй. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.8 дах заалтын дагуу ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгохоос өмнө палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулна, мөн хуулийн 38 дугаар зүйлийн 38.3 дах заалтын дагуу Газрын хэвлийг эзэмших, ашиглах явцад соёлын биет өв илэрвэл газрын хэвлийг ашиглагч ажлаа зогсоож, энэ тухай сум, дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг хариуцсан байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 4

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Ахуйн	Кемпийн талбайд битүүмжлэл сайтай хогийн цэг байгуулах эсвэл сав байршуулах	Ахуйн хог хаягдал	байршил	-	1	ҮА-ны зардал	Олборлолт явуулах бэлтгэх ажил	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.2
2.		Дүүргийн тохижилт үйлчилгээ хариуцсан байгууллагатай гэрээ байгуулж, үйлчилгээний хураамж төлөх	Ахуйн хог хаягдал	-	Гэрээний дагуу	-	350'000	Гэрээг жил бүр Төлбөрийг сар бүр төлөх	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.3, 10.2.7
3.		Хог хаягдлыг ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх. Ахуйн хог хаягдлыг	Ахуйн хог хаягдал	төрөл	ҮА-ны зардал	3	ҮА-ны зардал	Үйл ажиллагааны явцад байнга	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.1, 10.2.8

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
		ангилах ялгах төрөл: -Дахин ашиглах боломжтой - Хүнсний хаягдал - Бусад							
4.		Дахин боловсруулах болон ашиглах боломжгүй хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт тээвэрлэн зайлуулах	Хог хаягдлын ангилал	тн	ҮА-ны зардал	-	500*000	Сард 1-2	Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах,
5.		Дахин ашиглах боломжтой хог хаягдлыг түүхий эдийн цэгт нийлүүлэх	Ахуйн хог хаягдал	тн	ҮА-ны зардал	-	ҮА-ны зардал	Сард 1-2	устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
									ерөнхий шаардлага ²
6.		Тухайн жилд ашиглалт явуулаагүй талбайн хог хаягдлыг тогтмол цэвэрлэх	Ахуйн хог хаягдал	-	ҮА-ны зардал	-	ҮА-ны зардал	Байнга	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.10
7.		Үйлдвэрлэлийн хог хаягдлыг ангилан ялгаж, бүртгэлжүүлэх	Үйлдвэрлэлийн хаягдал	тн	ҮА-ны зардал	-	ҮА-ны зардал	Байнга	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.1
8.	Үйлдвэрийн	Дахин ашиглах боломжтой хаягдлыг түүхий эдийн цэгт нийлүүлэх /хаягдал дугуйг өөрийн уурхайн талбайн дотоод	Үйлдвэрлэлийн хаягдал	ш	ҮА-ны зардал	-	ҮА-ны зардал	Жилд 1 удаа	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.8

² БОАЖ-ын сайдын 2018 оны 11 дүгээр сарын 17 өдрийн А/443 дугаар тушаалын хавсралт

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
		замын хашлаганд хэрэглэх г.м/							
9.	Аюултай	Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж, кодлох, бүртгэл хөглөх	Аюултай хог хаягдал	-	ҮА-ны зардал	-	ҮА-ны зардал	Байнга	Хог хаягдлын тухай хуулийн 22-р зүйл
10.		Аюултай хог хаягдал үүсгэгчийн бүртгэлийн дугаар авна.	Аюултай хог хаягдал	-	ҮА-ны зардал	-	ҮА-ны зардал	2021	Хог хаягдлын тухай хуулийн 21-р зүйл
11.		Ашигласан тос, тосны шүүр зэрэг хаягдлыг тусгай цэгт хуримтлуулж, энэ төрлийн хаягдал хүлээн авдаг байгууллагад гэрээний дагуу нийлүүлэх	Аюултай хог хаягдал	л ш	ҮА-ны зардал	-	ҮА-ны зардал	Жилд 2 удаа	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.5

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг	
12.		Тэсрэх бодисын нийлэг уут, тэсэлгээний хэрэгслийн цаасан хайрцгийг мөн тусад нь цуглуулж устгах	энгийн хог хаягдал	ш	ҮА-ны зардал	-	Тэсэлгээний гэрээт компани хариуцна	Тэсэлгээ хийх бүрд	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.5	
13.		ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН НИЙТ ЗАРДАЛ						850'000		

11. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 5

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа								
1.	Ажилчдын хөдөлмөрийн тусгай нөхцөл алдагдах,	Ажилд шинээр орж байгаа хүн эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт орж магадлагаа гаргуулсан байна.	Эрүүл мэндийн үзлэг	-	ХАБЭА-н зардал		Шинэ ажилтан авах бүрт	Ил уурхайн аюулгүй байдлын дүрэм ³
2.	мэргэжлээс шалтгаалах өвчлөлд өртөх	Бүх ажилчдыг эмнэлгийн үзлэгт хамруулна	Ажилчдын эрүүл мэнд	40	ХАБЭА-н зардал		Жил бүр	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн 14-р зүйл
3.	Ажилчдын хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал алдагдах	Бүх ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас, хамгаалах хэрэгслээр бүрэн хангах	Хөдөлмөрийн нөхцөл	40	ХАБЭА-н зардал		жил бүр	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн 15-р зүйл
4.	Галын аюулгүй байдлын дүрэм	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа,	Уурхайн ХАБЭА,	-	ХАБЭА-н зардал		Уурхай эхлэх	Хөдөлмөрийн аюулгүй байдал

³ Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/231, А/368 дугаар хамтарсан тушаалын хавсралт

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	журам зөрчигдөх	галын аюулаас урьдчилан сэргийлэх дүрэм журам боловсруулж, түүнийг үйл ажиллагаандаа зайлшгүй дагаж мөрдөх	Галын аюулаас сэргийлэх				бэлтгэл ажлын хүрээнд бэлэн болгосон байх	эрүүл ахуйн тухай хуулийн 28.1.6
5.	Болзошгүй галын аюул	Гал унтраах хэрэгслийг байрлуулах, тэдгээрийн бэлэн байдлын үзлэг хийж, хяналт тавих	Галын эсрэг хэрэгсэл	-		ХАБЭА-н зардал		Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.6
6.	үүсэх, аюулын эсрэг бэлэн байдал хангагдахгүй байх	Аюулын гарц заасан самбар, аврах схем, галын аюулгүй байдлын хэрэгслийн байршил зэргийг тодорхой заасан зурагт хуудас, тэмдэг, тэмдэглэгээг байршуулах	Тэмдэг, тэмдэглэгээ	10-аас доошгүй байршилд		ХАБЭА-н зардал	Эхний жилд байршуулж, цаашид жил бүр тодотгол хийх	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн 28.1.1, MNS 4643:1998

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
7.	Түлшний хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдал	Шатах тослох материалын хадгалалт хамгаалалтанд онцгой анхаарч, тагны битүүмжлэл, даралтат хоолойн ажиллагааг шалгаж, ойр орчимд оч үүсгэх, механик гэмтлээс сэргийлэх	Түлш хадгалах сав	1		ХАБЭА-н зардал	үзлэгийг сард 1 удаа	Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм ⁴
8.	алдагдах, тэсэрч дэлбэрэх	Түлш хадгалах саванд аянга зайлуулагч, газардуулга хийж, эсэргүүцлийг нь мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хэмжүүлж баталгаажуулах	Түлш хадгалах сав	1		ХАБЭА-н зардал	Жилд 1 удаа	Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 11.4.4
9.	Гэнэтийн болзошгүй аюул, цахилгаанаас	Аянга зайлуулагчийг шаардлагатай бүх газруудад байрлуулж, газардуулгын эсэргүүцлийг	Богино холболт үүсгэж болзошгүй	-		ХАБЭА-н зардал	Жилд 1 удаа	MNS 5146:2002

⁴ Засгийн газрын 2016 оны 339 дүгээр тогтоолын хавсралт

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	үүдэлтэй аюул осол гарах	мэргэжлийн байгууллагаар хэмжүүлж баталгаажуулалт хийлгэж байх	тоног төхөөрөмж					
10.	Газар хөдлөлт	Гадаад овоолго үүсгэх, мөргөцгийн налуу зэргийг газар хөдлөлтийн бүс нутагт баримтлах норм дүрэм болон ТЭЗҮ-ийн дагуу төлөвлөн гүйцэтгэх	Овоолго, мөргөцөг	-	ҮА-ны зардал		Ашиглалтын шатанд байнга	-
11.	Цахилгааны холболтоос үүдэлтэй гал түймэр гарах	Цахилгаан тоног төхөөрөмж, гэрэлтүүлгийн угсралт, холболтыг стандартын дагууд хийж, тогтмол үзлэг хийж хяналт тавих	Бүх цахилгаан холболтууд	-	ХАБЭА-н зардал		үзлэгийг сард 1 удаа	Цахилгаан тоног төхөөрөмжийн зохион байгуулалтын дүрэм
Химийн бодисын эрсдэлийн менежмент								
12.	Тээвэрлэлтийн үед аюулгүй	Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний	Тээвэрлэлтийг гэрээт	-	Тэсэлгээний тусгай зөвшөөрөл		Байнга	Тэсэрч дэлбэрэх бодис,

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	байдал алдагдаж, хүний амь нас хохирох	хэрэгслийг ханган нийлүүлэгчээс худалдан авч, зөвшөөрөгдсөн чиглэлийн дагуу тээврийн болон аюултай ачааны стандартыг баримтлан тусгай тоноглон тээврийн хэрэгслээр аюулгүй байдлыг хангаж, харуул хамгаалалттай тээвэрлэх бөгөөд аюултай ачаа бараа тээвэрлэх тусгай зөвшөөрөлтэй байгууллага /тээврийн хэрэгслийн зөвшөөрөл, тээвэрлэлтийн маршрутыг цагдаагийн байгууллагаас авсан байх/ гүйцэтгүүлнэ.	компаниар хийж гүйцэтгүүлнэ.		бүхий компаниар гэрээгээр хийж гүйцэтгүүлэх бөгөөд тухайн компани аюулгүй ажиллагаа болон тухайн гарах зардлыг бүрэн хариуцаж ажиллана.		тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай 14.1	

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
13.	Дотоод тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдал алдагдах, осол гарах	Уурхай доторх агуулахаас тэсэлгээний ажлын байр хүртэл тэсрэх материалыг тээвэрлэхдээ (дотоод буюу технологийн тээвэрлэлт) байгууллагын удирдлагын /техникийн удирдлагын/ буюу түүний томилсон эрх бүхий албан тушаалтны тогтоосон маршрутаар тээвэрлэнэ.	Уурхай доторх тээвэрлэлт	-	ҮА-ны зардал	Байнга	Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны дүрэм"-ийн 147 ⁵	
14.	Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн	Тэсрэх бодис, тэслэх хэрэгслийг нарны шууд тусгалаас	Агуулах	2	ҮА-ны зардал	Байнга	Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний	

⁵ Засгийн газрын 2019 оны 313 дугаар тогтоолын хавсралт

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	хадгалалтын аюулгүй ажиллагаа алдагдах, хүний эрүүл мэндэд хохирол учрах	хамгаалсан зориулалтын агуулах байгуулан хадгалах, аюулгүй байдалд хяналт тавих Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тусдаа агуулахад хадгална.						хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 10-р зүйл, Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны дүрэм ⁶ , MNS 6458:2014
15.	Аянга цахилгаанаас үүсэлтэй осол гарах	Тэсрэх материал хадгалах агуулахыг аянгын хамгаалалтаар төхөөрөмжилж, үзлэг шалгалт хийж байх ⁷	Агуулахын аянгын хамгаалалт	2	ҮА-ны зардал		Аянга буух үеэс өмнөх улиралд жилд 1-ээс	“Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны дүрэм”-ийн ⁸ 899, 921-932

⁶ Засгийн газрын 2019 оны 313 дугаар тогтоолын хавсралт

⁷ Үзлэг шалгалтад дараах зүйл орно:

а) аянгын хамгаалалтын төхөөрөмжийн гаднах ерөнхий үзлэг;

б) аянгын хамгаалалтын газардуулагчийн эсэргүүцэл хэмжих;

с) аянгын хоёрдогч үйлчлэлийн хамгаалалтын төхөөрөмжийн холболтуудын шилжилтийн эсэргүүцлийг шалгах.

⁸ Засгийн газрын 2019 оны 313 дугаар тогтоолын хавсралт

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
							доошгүй удаа	
16.	Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн ашиглалтын хяналт алдагдах	Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн ашиглалт зарцуулалтын бүртгэл хөтөлж, холбогдох байгууллагад тайлагнах	Тэсрэх материал	Тэсрэх бодис-1 Өдөөгч -1	ҮА-ны зардал		Улиралд 1 удаа МХЕГ болон ЦЕГ, ТЕГ	“Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны дүрэм”-ийн ⁹ 597-615
Байгалийн гамшигт үзэгдэлд өртөхөөс сэргийлэх арга хэмжээ								
17.	Уурхайн байршил нь хойноосоо урд тал руугаа намссан, ерөнхийдөө талбайд дөрвөн талаас нь үерийн ус	Гэнэтийн үер, борооны уснаас хамгаалах шуудуу татах. Шуудууны урт 1240.5 м, хөндлөн огтлолын талбай 0.41 м ² , амсрын өргөн 1.6 м, ёроолын өргөн 0.45 м, гүн нь 0.4 м байна. Шуудуунаас гарсан хөрсийг уурхай талын	Шуудуу	Шуудууны газар шорооны ажлын хэмжээ 508.6 м ³	ҮА-ны зардал		Ашиглалт эхлэх бэлтгэл ажлын хүрээнд	“Ил уурхайн аюулгүй байдлын дүрэм”-ийн 476 ¹⁰

⁹ Засгийн газрын 2019 оны 313 дугаар тогтоолын хавсралт

¹⁰ Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/231, А/368 дугаар хамтарсан тушаалын хавсралт

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	орж ирж болзошгүй	шуудууны амсрыг дагуулан овоолно.						
Болзошгүй осол аваар								
18.	Мөргөцгийн нуралт үүсэх	Олборлолтын талбайн мөргөцгийн налууг ТЭЗҮ-д тусгагдсан хэмжээсийг баримтлан олборлолт явуулах	Олборлолтын талбай	24 ⁰	ҮА-ны зардал	Ашиглалтын жилүүдэд		ТЭЗҮ

12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Ашиглалтын үйл ажиллагаа явагдах үед байгаль орчинд учруулах сөрөг нөлөөлөл, байгаль орчны өөрчлөлтийг тухай бүр илрүүлэх, түүнийг бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал тодорхой орон зайд, тодорхой хугацааны дотор, тодорхой давтамжтайгаар ажиглалт, хэмжилт, хяналт явуулах. Үүнд тулгуурлан үйл ажиллагааныхаа явцад байгаль орчинд учруулж буй нөлөөлөл, түүний хэмжээ, цар хүрээ, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд гарч буй өөрчлөлтөд дүгнэлт хийж цаашид авах арга хэмжээг нарийвчлан төлөвлөж хэрэгжүүлнэ. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад байгаль орчны төлөв байдал өөрчлөлт орох, бохирдлын хэмжээ байгаль орчны стандарт, норм нормативаар тогтоосон хэмжээнээс хэтэрч илрэх тохиолдолд мэргэжлийн байгууллагад яаралтай хандаж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.

Хүснэгт 5

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
Агаар орчин								
1.	Азотын давхар исэл	1. Тоног төхөөрөмж ажиллаж буй байршлаас 10 м зайд	2,3-р улиралд	Жилд 2-3 удаа	42'350	82,700		MNS 4585:2016 MNS 5002:2000
4.	Хүхэрлэг хий							
5.	Нийт тоос (TSP)							
6.	Дуу шуугиан	2. Талбайн ерөнхий салхины чиглэлийн дээр 3. Кемпийн талбай						
7.	Нарийн ширхэглэгт тоосонцор (PM10, PM2.5)	Уурхайн ашиглалт явагдаж буй хэсгийн салхины доод талд	2-р улиралд	жилд 1-2 удаа	55'000	110'000		MNS 4585:2016
Хөрс								
8.	Хөрсний агрохимийн үзүүлэлт	Тухайн жилийн ашиглалт явуулж буй талбайд 2-3 цэг сонгоно	2,3-р улиралд	Жилд 2-3 удаа	25'000	66'630		MNS 3298:1991 MNS 3297:2019

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
9.	Хүнд металлын бохирдол	Нөлөөлөлд бага өртсөн талбайд 1-2 цэг сонгоно	2,3-р улиралд	Жилд 2-3 удаа	48'510	97,020		MNS 5850:2019 MNS 3298:1991
10.	Микробиологийн бохирдол	1. Кемпийн талбай дахь хог хаягдлын цэг 2. Бохир ус цэвэрлэх байгууламжийн орчимд	2,3-р улиралд	Жилд 2-3 удаа		Хог хаягдлын зардалд тооцсон		MNS 3298:1991 MNS 6341:2012
Ус								
11.	Физик-химийн шинж чанар	1. Өрөмдмөл худаг 2. Тахилт орчмын гэр хорооллын ус түгээх байр 1-2 сонгоно	2,3-р улиралд	Жилд 2 удаа	33'000	198'000		MNS 0900:2018
12.	Микро элементийн агууламж				66'000	396'000		
13.	Физик-химийн шинж чанар	Ажилчдын ус нөөцлөх сав эсвэл гал тогооны хэсгийн ус гаргалгаа	2,3-р улиралд	Жилд 2-3 удаа	33'000	99'000		MNS 0900:2018
14.	Эрүүл ахуйн үзүүлэлт				33'550	100'650		
Ургамал								
13.	Ургамлын мониторинг, зүйлийн бүрдлийн судалгаа	Лицензийн талбай	2 жилд 1 удаа	1	200'000	300'000	БО-ны мэргэжил тэн	Фотомониторингийн арга, друдегийн арга
Амьтан								
14.	Ажиглалт, судалгаа	Сонгинохайрхан уул	5 жилийн хугацаанд 2 удаа	1	100'000	200'000	УБ хот орчмын амьтны	Байгаль орчныг хамгаалах

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
							ажиглалт судалгааны ажилд дэмжлэг үзүүлэх	тухай хуулийн 3.1.5
	Нийт	Төлөвлөгөөт онд			465,550	1'650'000		

14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

“МОНФУКТ ХХК” компанийн захирлын тушаалаар компанийн хөдөлмөр хамгаалал, байгаль орчны асуудал хариуцсан албан тушаалтныг томилж, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөө болон байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтийг компанийн захиргааны өмнө хариуцан ажиллана.

Хүснэгт 6

Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан хэлтэс
Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, хяналт, шинжилгээ хийх	ҮА-ны зардал	тухайн оны үйл ажиллагаа эхлэхээс дуусах хүртэл	Байгаль орчны холбогдох мэргэжилтэн
Байгаль орчныг хамгаалах ажлын гүйцэтгэлийн дотоод хяналт шалгалт /ач холбогдол, чанартай гүйцэтгэсэн эсэхийг хянах	ҮА-ны зардал	Сар бүр	Дотоод хяналт шалгалтын ажилтан, удирдлагууд

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө гарган холбогдох байгууллагуудад хүргүүлж, тайлант хугацааны эцэст дүгнүүлэх	ҮА-ны зардал	Жилд 1 удаа	Байгаль орчны мэргэжилтэн,
Компаний удирдлагуудын хяналт, шалгалт, дүн шинжилгээ	ҮА-ны зардал	Улиралд 1 удаа	Дээд удирдлагууд
Төсөвт зардлыг Жил бүрийн ҮА-ны зардалд оруулах			

15. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ, ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ

Хүснэгт 6

Байгаль орчны хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар/ байршил
Байгаль орчин аялал жуулчлалын яам	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Тухайн жилд байгаль орчныг хамгаалах, орчны өөрчлөлтийг хянах хөтөлбөр агуулсан байгаль орчны менежментийн	Тухайн жилийн 12 дугаар сар	БОМТ-нд орсон нутгаас санал авч байгаль орчны төрийн захиргааны төв байгууллагаар хянуулж батлуулах	Орон нутаг, Байгаль орчин аялал жуулчлалын яам

		тайлагнах батлуулах			
Сонгино-Хайрхан дүүргийн засаг даргын тамгын газрын байгаль орчны газар	БОМ-ийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан .	Бүх ажиллагсад ажилд гарахын өмнө хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгдөг	Тухай жилийн 11 сарын 1-ний дотор	Төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлтийн дүгнэлт	Сонгино-Хайрхан дүүргийн засаг даргын тамгын газар болон 33-р хорооны ИТХ
СХД-ийн ЗДТГ-ын хөгжлийн бодлогын хэлтэс, байгаль орчны газар, МХГ, сав газрын захиргаа, 33-р хорооны засаг даргын тамгын газрын төлөөлөл байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч газрын даамал	Төслийн төслийн талбай дээр хэрэгжсэн ажлыг тайлагнах	Төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлтийг хянах	Тухайн жилийн 12 сарын 1-ний дотор	Төлөвлөгөөний биелэлтийг хянаж, дараа жилийн төлөвлөгөөнд санал авах	Сонгино-Хайрхан дүүргийн засаг даргын тамгын газар, 33-р хорооны ИТХ
Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газар	Тайлагнах танилцаж баталгаажуулах	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн	Тухайн жилийн 12 сард багтаана	Дараа оны төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө	Байгаль орчин аялал жуулчлалын яам

		тайланг баталгаажуулах		зардлын хэмжээг батална.	
--	--	---------------------------	--	-----------------------------	--

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРДАЛЫН НЭГДСЭН ХҮСНЭГТ

Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан хэлтэс
СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	1,000,000	тухайн оны үйл ажиллагаа эхлэхээс дуусах хүртэл	Байгаль орчны холбогдох мэргэжилтэн
НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭ	500,000	Сар бүр	Дотоод хяналт шалгалтын ажилтан, удирдлагууд
БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	8,000,000	тухайн оны үйл ажиллагаа эхлэхээс дуусах хүртэл	Дотоод хяналт шалгалтын ажилтан, удирдлагууд
ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	850,000	тухайн оны үйл ажиллагаа эхлэхээс дуусах хүртэл	Дотоод хяналт шалгалтын ажилтан, удирдлагууд
ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	1,650,000	тухайн оны үйл ажиллагаа эхлэхээс дуусах хүртэл	Дотоод хяналт шалгалтын ажилтан, удирдлагууд
ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан	тухайн оны үйл ажиллагаа эхлэхээс дуусах хүртэл	Дотоод хяналт шалгалтын ажилтан, удирдлагууд
Тухайн жилийн нийт төсөв		12,000,000	

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, сөрөг нөлөөллийг бууруулах хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг сайжруулах, дүйцүүлэн хамгаалах чиглэлээр нийт **12,000,000** төгрөг зарцуулагдах бөгөөд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.10-т заасны дагуу байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд зарцуулагдах төсвийн 50% буюу **6,000,000** төгрөгийг тусгай дансанд байршуулна

16. ХАВСРАЛТУУД

“Монфрукт” ХХК нь “Баруун туруун-2 барилгын чулууны ордыг ашиглах төсөл”-ийг хэрэгжүүлэхдээ байгаль орчны хамгааллын хүрээнд дараах хууль тогтоомж, дүрэм журам, стандартыг мөрдлөг болгон ажилласан

➤ Монгол улсын хууль

Д/д	Хуулийн нэр	Батлагдсан он
1	Агаарын тухай хууль /шинэчилсэн найруулга/	УИХ, 2012
2	Байгаль орчныг хамгаалах тухай хууль	УИХ, 1995
3	Газрын тухай хууль /шинэчилсэн найруулга/	УИХ, 2002
4	Газрын хэвлийн тухай хууль	УИХ, 1988
5	Ургамал хамгааллын тухай хууль /шинэчилсэн найруулга/	УИХ, 2007
6	Усны тухай хууль /шинэчилсэн найруулга/	УИХ, 2012
7	Хог хаягдлын тухай хууль	УИХ, 2012
8	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль	УИХ, 2012

➤ Монгол улсын үндэсний стандартууд

Д/д	Стандартын нэр	Дугаар
1	Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага	MNS 4585:2007
2	Агаарын чанарын нийтлэг асуудал. Нарийн ширхэгтэй тоосыг тодорхойлох арга	MNS 5365:2005
3	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага	MNS 5885:2008
4	Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томъёо, тодорхойлолт	MNS 5914:2008
5	Байгаль орчин. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллгаагаар эвдэрсэн газрын ангилал	MNS 5915:2008

6	Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт	MNS 5916:2008.
7	Байгаль орчин. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн шаардлага	MNS 5917:2008.
8	Байгаль орчин. Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн шаардлага	MNS 5918:2008
9	Байгаль орчны хамгаалал. Усан мандал газрын доорх усны бохирдлоос хамгаалах	MNS 3342:1982
10	Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ	MNS 5850:2008.
11	Усан мандал.Газар доорх усыг бохирдлоос хамгаалах ерөнхий шаардлага	MNS 3342:82
12	Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага	MNS 5344:2011
13	Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт	MNS 0900:2005

➤ Байгаль орчны салбарын дүрэм, журам

Д/д	Дүрэм, журмын нэр	Батлагдсан он/дугаар
1	Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам	Байгаль Орчны Сайдын 2007 оны 6 дугаар тушаал
2	“Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал”	БОНХАЖЯамын А-138 тушаал
3	Уурхай, уулын баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам	Уул уурхай хүнд үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хамтарсан тушаал А/181, А/458

Хавсралт материалуудын жагсаалт

- 1. БОННУ БАТЛАГДСАН НҮҮР (ХУУЛБАР, СКАЙН)**
- 2. УЛСЫН БҮРТГЭЛ ГЭРЧИЛГЭЭ (ХУУЛБАР, СКАЙН)**
- 3. АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ (ХУУЛБАР, СКАЙН)**
- 4. НӨӨЦИЙН ТУШААЛ, ЭБМЗ-ИЙН ДҮГНЭЛТ (ХУУЛБАР, СКАЙН)**
- 5. УС АШИГЛАЛТЫН ДҮГНЭЛТ (ХУУЛБАР, СКАЙН)**
- 6. БОХ-3 МАЯГ (ХУУЛБАР, СКАЙН)**
- 7. УУЛЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НҮҮР**
- 8. БАРЬЦАА ХӨРӨНГӨ БАРИМТ ХУУЛБАР (ХУУЛБАР, СКАЙН)**



“МОНФРУКТ” ХХК -Д

**МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ**

Арцатын 624, 23 дугаар хороо,
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17100
Утас: 26 61 71, Цахим шуудан: contact@met.gov.mn,
Цахим хуудас: www.met.gov.mn

2024.10.14 № 12/4762
танай _____-ны № _____-т

Ерөнхий үнэлгээний дүгнэлт хүргүүлэх
тухай

Танай байгууллагаас боловсруулан ирүүлсэн Улаанбаатар хотын Сонгионхайрхан дүүрэгт орших MV-016848 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Барилгын чулууны ордыг ил аргаар ашиглах” төсөлд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Засгийн газрын 2023 оны “Журам батлах тухай” 58 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх журам”-д заасан аргачлалын дагуу байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийж, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай гэж үзэв.

Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудаст заасан нарийвчилсан үнэлгээний явцад тодруулах асуудлууд, онцгойлон анхаарах чиглэлийг үндэслэн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэж 2025 оны 2 дугаар улиралд багтаан тус яаманд ирүүлэхийг үүгээр мэдэгдье.

Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудсыг хавсаргав.

Хавсралт 3 хуудастай.

ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ



ГЭНХМӨНХ

1524001851

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ

ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУУДАС

2024 оны 10-р сарын 03

Улаанбаатар хот

Дугаар 2024/ОА-51

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг: “МОНФРУКТ” ХХК, Улаанбаатар, СБД, 1-р хороо, Юнион Бюлдинг 1102 тоот.

Холбоо барих утас, И-мэйл хаяг: 11301664, 70146999.

Төслийн нэр: Улаанбаатар хотын Сонгионхайрхан дүүрэгт орших MV-016848 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Барилгын чулууны ордыг ил аргаар ашиглах” төсөл.

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, байршил: Сонгионхайрхан дүүргийн 33-р хороо.

Санал: Дүүргийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 01/2579 дугаар албан бичиг, И-Бизнес цахим системийн **077-2410-000015** тоот хүсэлтийг үндэслэв.

	Ерөнхий үнэлгээний гол шалгуурууд	Ний цсэн	Нийцээгүй	Нарийвчилсан үнэлгээ хийх шаардлагатай	Үндэслэл, тайлбар
Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийн нийцэл	Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа байгаль орчныг хамгаалах болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль тогтоомжийн холбогдох заалт			Тийм	Нарийвчилсан үнэлгээний явцад хууль тогтоомжийн нийцлийг нарийвчлан тодорхойлох
Төрийн бодлого, шийдвэрийн нийцэл	Төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, Стратегийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийн холбогдох заалт	Тийм			
Төслийн байршил, түүнтэй холбогдох шалгуурууд	Хуулиар хамгаалагдсан газар нутаг байгаа эсэх (урсац бүрэлдэх эх, ойн болон усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, хилийн хамгаалалтын бүс, орон нутгийн тусгай хамгаалалттай газар г.м)			Тийм	Хууриар хоргилсон, хязгаарлсан газар байгаа эсэхийг нарийвчилсан үнэлгээний шатанд тодорхойлох
	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь хүний нөлөө, байгаль цаг уурын өөрчлөлтөд эмзэг, мэдрэмтгий эсэх			Тийм	
	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний ойр орчимд улс, орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлөсөн, сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй газар байгаа эсэх			Тийм	
	Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл үүсгэх эсэх			Тийм	
Төслийн байгаль орчны нөлөөллийн урьдчилсан үнэлгээ	Агаарын чанар				
	Бохирдуулагч болон аюултай, хортой бодис агаар мандалд ялгаруулах, эсэх			Тийм	
	Дуу чимээ, доргио чичиргээ, гэрлийн болон дулааны нөлөөлөл, цахилгаан соронзон цацраг үүсэх, эсэх			Тийм	
	Усан орчин				
	Гадаргын болон газрын доорх усны нөөцийн хомсдол үүсэх, эсэх			Тийм	
	Цэнгэг усны нөөцийг ашиглах, эсэх			Тийм	



	Гадаргын болон газрын доорх усанд бохирдол үүсэх, эсэх			Тийм	
Хөрсөн бүрхэвч					
	Хөрсөн бүрхэвч эвдрэх, эсэх			Тийм	
	Хөрс бохирдуулах эсэх			Тийм	
	Хөрс доройтох, цөлжих эсэх			Тийм	
Ургамлан нөмрөг					
	Ургамалан нөмрөг, ой мод өртөх эсэх			Тийм	
	Ховор, нэн ховор ургамлын төрөл зүйлс өртөх, эсэх			Тийм	
Амьтны аймаг					
	Зэрлэг амьтдын амьдрах орчинг доройтуулах, эсэх			Тийм	
	Ховор, нэн ховор амьтан өртөх, эсэх			Тийм	
Нийгмийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ	Нутгийн оршин суугчид				
	Газар эзэмших, ашиглах эрх зөрчигдөх, эсэх			Тийм	
	Нутгийн оршин суугчдын нийгмийн байдалд сөрөг нөлөөлтэй, эсэх			Тийм	
	Нөлөөлөлд өртөж болзошгүй төв, суурин газар байгаа, эсэх			Тийм	
	Нүүлгэн шилжүүлэх асуудал үүсэх, эсэх			Тийм	
	Түүх, соёлын биет өв				
	Сөрөг нөлөөлөлд өртөх түүх, соёлын үнэт зүйлс бий эсэх			Тийм	
	Хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөлөл				
	Нутгийн иргэд, оршин суугчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эсэх			Тийм	
	Төслийн бүх үе шатанд хүний эрүүл мэнд, амь насанд эрсдэл үүсэх эсэх			Тийм	
Нэгдсэн дүгнэлт:					
Улаанбаатар хотын Сонгионхайрхан дүүрэгт орших MV-016848 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Барилгын чулууны ордыг ил аргаар ашиглах” төсөлд батлагдсан аргачлалын дагуу Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай гэж үзлээ.					
Онцгойлон анхаарах зүйлс:					
1. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг батлагдсан Техник эдийн засгийн үндэслэлд тулгуурлан хийлгэх бөгөөд олборлолтын технологийн дарааллыг нарийвчлан тодорхойлж, технологийн сонголтод үнэлэлт дүгнэлт өгөх;					
2. Төслийн үйл ажиллагаанаас хүний эрүүл мэнд, байгаль орчин /агаар, ус, хөрс, амьтан, ургамал г.м/-д үзүүлэх сөрөг нөлөөлөл, түүний хамрах хүрээ, учруулах хохирлын хэмжээг тооцож, нийлбэр үнэлгээг гарган уг төслийн экологи, эдийн засгийн үр ашигтайгаар хэрэгжүүлэх боломжтой эсэх талаар дүгнэлт гаргах;					
3. Тухайн орд газрын гадаргын болон газрын доорх усны харилцан хамаарал, уст үеийн хөдөлгөөн, тархалтыг олборлох технологитой уялдуулан нарийвчлан судалж, эрх бүхий байгууллагаар усны нөөцийн дүгнэлт гаргуулах;					
4. Төслийн бүрэлдэхүүн хэсгээс ялгарах бохирдлыг хэмжээ, түүний тархалт, нөлөөллийг хүрээг нарийвчлан тодорхойлж, зураглал үйлдэн тайланд хавсаргах;					

5. Төслийн үйл ажиллагаанаас нөлөөлөлд өртөх талбайн хэмжээг нарийвчлан тооцож, үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг тухай бүс нутагт орших эвдрэлд орж, эзэнгүй орхигдсон газрыг нөхөн сэргээх замаар биологийн олон янз байдлын амьдрах орчныг сэргээхээр саналыг боловсруулж, шаардагдах зардлыг тайланд тусгах;
6. УУХҮ-ийн болон БОАЖ-ын сайд нарын 2019 оны 8-р сарын 28-ны өдрийн А/181, А/458 дугаар тушаалаар батлагдсан "Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам"-ын дагуу Ордын ашиглалт дууссаны дараах хаалтын нөхөн сэргээлт, мониторинг хийх төслийг боловсруулж, хаалтын ажлын каледарчилсан төлөвлөгөө, зардлын тооцоог урьдчилан тооцож, тайланд тусгах;
7. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө /Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр/-г боловсруулж, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлыг тооцож ирүүлэх;
8. "Байгаль орчныг хамгаалах тухай" хуулийн 10¹-р зүйлд заасны дагуу төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэд байгаль орчны төлөвлөгөөт аудитыг төслийн 2 дахь жилээс хийлгэх, аудитын дүгнэлт зөвлөмжийг холбогдох газруудад хүргүүлэх хугацаа, зардлыг тайланд тусгах;
9. Уг төсөл хэрэгжиснээр байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх эерэг, сөрөг нөлөөллийн талаар болон эцэслэн боловсруулсан БОННУ-ний ажлын тайланг төсөл хэрэгжих баг/хорооны ИНХ-аар хэлэлцүүлж, хурлын тэмдэглэл, шийдвэрийг тайланд хавсарган саналыг тусгах;
10. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газартай давхцалтай эсэх лавлагаа БОУАӨЯ-наас авч тайланд хавсаргах.
11. Батлагдсан техник, эдийн засгийн үндэслэлийн тушаал, дүгнэлтийг тайланд хавсаргах.
12. Засгийн газрын 2018 оны 379 дүгээр тогтоолоор батлагдсан "Тусгай зориулалтаар авто зам, замын байгууламж барих, ашиглах журам"-ын хэрэгжилтийг хангаж байгаа талаар тусгайлан дүгнэлт гаргаж, нарийвчилсан үнэлгээний тайланд тусгах.
13. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд төслийн хүчин чадалд тулгуурлан мод тарих, модны төрөл зүйл, тоо хэмжээг тайланд тусгах;

Бусад зүйлс:


1. Төслийн үйл ажиллагаатай холбогдуулж орон нутгийн захиргааны болон мэргэжлийн хяналтын байгууллагаас тавигдах нэмэлт шаардлагыг тухай бүрт ханган биелүүлэх;
2. Нарийвчилсан үнэлгээний тайланд шүүмж хийлгэн дүгнэлт, шийдвэр гаргуулах асуудлыг ерөнхий үнэлгээгээр тогтоосон хугацаан хэрэгжүүлэх;
3. Төслийн хүчин чадал, техник, технологит өөрчлөлт орсон тохиолд ерөнхий үнэлгээнд тухай бүрт хамрагдаж шийдвэр гаргуулж ажиллах шаардлагатай болно.

Дээрх дурьдсан арга хэмжээг цаг хугацаанд ханган биелүүлээгүй тохиолдолд Ерөнхий үнэлгээний дүгнэлтийг хүчингүй болгож, "Зөрчлийн тухай" хуулийн 7.1 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасны дагуу хариуцлага тооцдог болохыг анхаарна уу.

Ерөнхий үнэлгээ хийсэн: БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ШИНЖЭЭЧ Гарын үсэг:  О.АМАРСАНАА	Ерөнхий үнэлгээний үр дүнг зөвшөөрсөн: "МОНФРУКТ" ХХК-НИЙ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Гарын үсэг:  Э.ТАМИР
--	---

БАТЛАВ:
ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ

ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ



Г. ЭНХМӨНХ

Б. ГАНБОЛД

МОНФРУКТ ХХК-НИЙ БАРИЛГЫН ЧУЛУУНЫ ОРДЫГ МЭЛ АРГААР АШИГЛАХ
ТӨСӨЛ -ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН РЕГИСТРИЙН ДУГААР:
6293956.



ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГА:
"ТӨГРӨГ БАЯН ХАНГАЙ" ХХК

Нэр: Гарын үсэг:



ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:
МОНФРУКТ ХХК

Нэр: Гарын үсэг:



2025 ОН



АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗАР

АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар *MV-016848*

Ашигт малтмалын тухай Монгол улсын хуулийн 26 дугаар зүйлийг үндэслэн

Улаанбаатар аймаг /хот/-ийн

Сонгинохайрхан сум /дүүрэг/-ын

Баруун туруун-2 нэртэй газарт орших

130.36 гектар талбай бүхий уурхайн талбайд хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу ашигт малтмал ашиглахыг

зөвшөөрч улсын бүртгэлийн 26/2628 тоот гэрчилгээтэй

“Монфрукт” ХХК -д

энэхүү тусгай зөвшөөрлийг 2011.06.15 дуустал

хугацаагаар олгов.

Тусгай зөвшөөрөл хавсралтгүй бол хүчингүй.



Д. БАТХУЯГ

2011 оны 06 сарын 15 өдөр

Улаанбаатар хот



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ

MV-016848

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

Дэс дугаар	Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл	Огноо, гарын үсэг, тэмдэг
001-NM	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон 2011.06.15, дуусах хугацаа 2041.06.15Тусгай зөвшөөрлийн 1 дахь/дэх жилийн төлбөрийг төлөвКадастрын хэлтсийн даргын 2011.06.08-ний 561 тоот шийдвэр	2011-06-15 АМГ КАДАСТРЫН ХЭЛТЭС ХТХ0058
002-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 2 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2012.06.15 – 2013.06.15 хүртэл	2012-06-12 АМГ КАДАСТРЫН ХЭЛТЭС ХТХ0058
003-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 3 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2013.06.15 – 2014.06.15 хүртэл	2013-05-20 АМГ КАДАСТРЫН ХЭЛТЭС ХТХ0058
004-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 5 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2015.07.24 – 2016.07.24 хүртэл	2015-09-18 АМГ КАДАСТРЫН ХЭЛТЭС ХТХ0058
005-RN	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийг цуцлахКадастрын хэлтсийн даргын 2014.06.30-ны 278 тоот шийдвэр	2015-06-30 АМГ КАДАСТРЫН ХЭЛТЭС ХТХ0058
006-CE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: 2015.09.11 өдрийн 735 шийдвэрШийдвэрийн тэмдэглэл: КХ-ийн даргын 2014/06/30-ны 278 тоот шийдвэрийг хүчингүй болгосон. Хүчин тоголдор хугацааг 2041/07/24-ний өдрөөр тооцож 5 дахь жилийн төлбөрийг хүлээн авч шийдвэрлэхийг даалгасныг бүртгэв.	2015-11-26 АМГ КАДАСТРЫН ХЭЛТЭС ХТХ0058
007-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 6 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2016.07.24 – 2017.07.24 хүртэл	2016-08-04 АМГ КАДАСТРЫН ХЭЛТЭС ХТХ0058



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ

MV-016848

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.


Дэс дугаар	Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл	Огноо, гарын үсэг, тэмдэг
008-FE	<ul style="list-style-type: none">Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 7 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2017.07.24 – 2018.07.24 хүртэл	2017-04-26
001	<ul style="list-style-type: none">Тусгай зөвшөөрлийн 9 дэх жилийн төлбөр төлснийг тэмдэглэв. Хугацаа 2020.04.24 - 2021.04.24 хүртэл	2020.04.27 НБОГ-ын дарга Э.Баттулга
002	<ul style="list-style-type: none">Тусгай зөвшөөрлийн 10 дахь жилийн төлбөр төлснийг тэмдэглэв. Хугацаа 2021.04.24- 2022.04.24 хүртэл	2021.07.21 НБОГ-ын дарга М.Нямбаяр
003	<ul style="list-style-type: none">Тусгай зөвшөөрлийн 11 дэх жилийн төлбөр төлснийг тэмдэглэв. Хугацаа 2022.04.24 - 2023.04.24 хүртэл	НБОГ-ын дарга М.Нямбаяр
004	<ul style="list-style-type: none">Тусгай зөвшөөрлийн 12 дахь жилийн төлбөр төлснийг тэмдэглэв. Хугацаа 2023.04.24 - 2024.04.24 хүртэл	НБОГ-ын дарга
005	<ul style="list-style-type: none">Тусгай зөвшөөрлийн 13 дахь жилийн төлбөр төлснийг бүртгэв. Хугацаа 2024.04.24-2025.04.24 хүртэл	НБОГ-ын дарга Р.Энхтайван
006	<ul style="list-style-type: none">Тусгай зөвшөөрлийн 14 дэх жилийн төлбөр төлснийг бүртгэв. Хугацаа 2025.04.24-2026.04.24 хүртэл	НБОГ-ын дарга Д.Бат-Өлзий



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 2 ДУГААР ХАВСРАЛТ

MV-016848

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

Хөдөлгөөний код	Хөдөлгөөний тайлбар	Хүчин төгөлдөр талбайн хэмжээ /га/	Хасагдах талбайн хэмжээ /га/	Тусгай зөвшөөрлийн талбайн солбицлууд, гарын үсэг, огноо, тамга		
				#	Уртраг	Өргөрөг
001-NM	<ul style="list-style-type: none">Ашиглалтын тусгай зөвшөөрлийг анх олгосон 2011.06.15	130.36 Га	0 Га	1	106° 38' 41.32"	47° 56' 0.78"
				2	106° 37' 46.32"	47° 56' 0.78"
				3	106° 37' 46.34"	47° 56' 37.78"
				4	106° 38' 41.82"	47° 56' 37.78"
				2011-06-15  Э.Заяабат -а		



МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000281314

2008.06.05

/ Бүртгэсэн он, сар, өдөр /

9011156027

/ Хувийн хэргийн дугаар /

2678586

/ Регистрийн дугаар /

Монфрукт

Хязгаарлагдмал хариуцлагатай
компани

/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм

/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр

/ шийдвэрийн нэр /

01

/ дугаар /

2001.11.08

/ он, сар, өдөр /

0729

46100

/ Код /

Ашигт малтмалын ашиглалт /2011.06.15-2041.06.15/

Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа

/ Үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй

/ хугацаа /

2

/ гишүүдийн тоо /

61,125.00

/ хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Баянгол, 19-р хороо, чингүнжав, „ Утас1: 11301664, Утас2: 70146999, Факс:

/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗАР

/ Бүртгэсэн байгууллагын нэр /


УЛСЫН БҮРТГЭГЧ

/тэмдэг/


Л.ПҮРЭВЖАРГАЛ


/гарын үсэг/

Гэрчилгээ дахин олгосон 2023 он 05 сар 05 өдөр



Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Энхтүвшин овогтой Тамир-г Гүйцэтгэх захирал -р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.	2020.09.29	 Д.Гангамөрөн Л.Пүрэвжаргал
2	Дахин гэрчилгээ олгов.	2023.05.05	



Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.



АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2011 оны 05 сарын 09 өдөр

Дугаар 185

Улаанбаатар хот

Нөөц хүлээн авч, бүртгэх тухай

“Ашигт малтмалын тухай хууль”-ийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэг, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2011 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдааны ХХ-07-04 дүгээр дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


Нэг. “Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн нутагт орших Баруун туруун-2-ын барилгын чулууны ордод 2010 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайлан” (Ордын нөөц 2011 оны 01 дүгээр сарын 01-ний байдлаар) дахь барилгын чулууны бодитой (В) зэргийн нөөцийг 1221000,0м³-ээр шинжээчийн тооцоолсон хувилбараар, хавсралтын дагуу хүлээн авсугай.

Хоёр. Хуралдааны энэхүү дүгнэлтийн дагуу хүлээн авсан барилгын чулууны нөөцийг ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэхийг Геологи, мэдээллийн тасаг (Г.Алтанхуяг)-т зөвшөөрсүгэй.

Гурав. Баруун туруун-2 барилгын чулууны ордын дээрхи нөөцөд тулгуурлан, уг ордын дайргыг ашиглах техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах боломжтой гэж үзсүгэй.

Дөрөв. Энэхүү дүгнэлтийн 10, 11-д заасан зүйлийг цаашдын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг “Монфрукт” ХХК (Я.Ган-Эрдэнэ)-д анхааруулж, заасан зүйлийг зөвшөөрсүгэй.

Тав. Хайгуулын ажлын үр дүнгийн тайланг, хээрийн судалгааны анхдагч материал, тайлангийн бичвэрийн дискийн хамт ЭБМЗ-ийн хуралдааны энэхүү дүгнэлт, түүний дагуу гаргасан АМГ-ын даргын тушаалыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Геологи, мэдээллийн тасагт хүлээлгэн өгөхийг “Монфрукт” ХХК (Я.Ган-Эрдэнэ)-д даалгасугай.



Д.БАТХУЯГ

ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ
АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗАР
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ

*2011 оны 04 дүгээр
сарын 15-ны өдөр*

*Улаанбаатар
хот*

Дугаар ХХ-07-04

*Улаанбаатар хотын Сонгинохайрхан
дүүргийн нутагт орших Баруун туруун-2-
ын барилгын чулууны ордод 2010 онд
гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр
дүнгийн тайланг хэлэлцсэн тухай*

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн нутагт орших Баруун туруун-2 барилгын чулууны ордод 2010 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгээр геологич У.Энхтайваны боловруулсан тайлан, уг тайлан дахь барилгын чулууны ордын нөөцийн тооцоонд инженер МУ-ын зөвлөх инженер, геологич С.Алтангэрэл, барилгын чулууны түүхий эдийн чанарт МУ-ын барилгын материалын зөвлөх инженер Ч.Оч нарын хийсэн шинжээчийн дүгнэлтийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд дараахь **ДҮГНЭЛТ**-ийг гаргаж байна.

1. “Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн нутагт орших “Баруун туруун-2” нэртэй газар 14854Х дугаартай 130 га талбайтай хайгуулын тусгай зөвшөөрлийг АМГазрын ГУУКадастарын Хэлтэсээс 2009 оны 04-р сарын 16-ны өдөр 2678586 тоот регистрийн дугаартай “Монфрукт” ХХК-д олгосон байна.

“Монфрукт” ХХК нь тусгай зөвшөөрөлтэй 130 га талбайд хайгуулын ажил гүйцэтгэж, барилгын чулууны бодитой (В) нөөцийг тогтоож, хайгуулын зардалд 9773200 төгрөг зарцуулсан байна.

2. “Баруун туруун-2” нэртэй барилгын чулууны орд нь Засаг Захиргааны хуваариар Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн нутагт орших ба Улаанбаатар хотоос баруун-хойш 30-аад км-т оршино.

Уул зүйн байрлалаар ордын район нь Хэнтийн уулархаг мужийн баруун-урд хэсэгт харьяалагдах бөгөөд L-48-10 хавтгайд 1:100000-ны масштабтай зураг дээрхи газар зүйн солбицол нь:

1. 47°56'36" ХӨ	106°37'45" З.У
2. 47°56'36" ХӨ	106°38'40" З.У
3. 47°55'59" ХӨ	106°38'40" З.У
4. 47°55'59" ХӨ	106°37'45" З.У

3. 1944 онд геологичид Ю.С.Желубовский, М.А. Анпилов нар Улаанбаатар хот орчмын талбайд 1:200000 ны масштабтай геологийн зураглалын ажил хийжээ.

Энэ ажлын дүнд Улаанбаатар хот болон түүний орчмын талбайд тоосгоны шаврын 14 орд, элсний 3 орд илрүүлсэн байна.

1959 онд Монгол улсын СнЗ-ийн дэрэгдэх Барилгын хорооны хүсэлтээр ЗХУ-ын (хуучин нэрээр) Барилгын материалын Яамны мэрэгжилтнүүдийн баг Туул голын хөндийд элс-хайрганы хольцын эрэл, хайгуулын ажил хийснээр Улаанбатарын элс-хайрганы хольцын ордыг илрүүлэн нөөцийг нь 2046.0 мян.м³-ээр үнэлжээ.

4. “Монфрукт” ХХК нь ашигт малтмалын хайгуулын 14854Х тоот тусгай зөвшөөрөлтэй “Баруун туруун-2” нэртэй талбайд хайгуулын ажлыг эрлийн маршрут, өрөмдлөг, дагалдах сорьцлолтын болон топогеодезийн ажлуудаар хийж гүйцэтгэсэн байна.

Хайгуулын ажлыг 3-р сард HANJIN POWER 4000 маркийн эргэлтэт өрмийн машинаар хийж гүйцэтгэлээ.

Барилгын чулууны хайгуул хийсэн 30,0 га талбайд 1:2000-ны масштабын байр зүйн зураглалыг “Жи Ди Эс Эс” ХХК хийж, хайгуулын бүх малталтуудыг Улсын Геодезийн Тулгуур Сүлжээнд холбуулжээ.

Хайгуулын ажлаар барилгын чулууны судлагдсан зузаан нь 9.0-29.0 м-т хэлбэлзэх ба дундажаар 16.5 м байна.

5. Ордод өрөмдсөн хайгуулын бүх цооногуудаас 24 ш чөмгөн дээж авсан ба эдгээрээс 22 дээжийг физик-механикийн хураангуй, 2 ш дээжийг физик-механикийн бүрэн шинжилгээнд, 1 ш дээжийг лаборатори-технологийн ба бетоны найрлага тогтоох туршилтанд, 2 дээжийг элэгдэл тодорхойлох шинжилгээнд, 2 дээжийг урвалжих чадвар, сульфат тэсвэрлэлтийн шинжилгээнд, 2 дээжийг химийн шинжилгээнд, 3 дээжийг цацраг идэвхижилийн шинжилгээнд тус тус авсан болно.

Дайрганы ширхэгийн дундаж нягт 2.70-2.73 г/см³ дундажаар 2.72 г/см³, нимгэн үзүүрлэг хэсэг 7.2-7.7% дундажаар 7.4%, шаварлаг-тоосорхог хольц 0.3-0.4 дундажаар 0.3%, нягт 2.72-2.74 г/см³ дундажаар 2.73 г/см³, ус шингээлт 0.43-0.59% дундажаар 0.51%, сүвэрхэг чанар нь 0.36-0.73%, дундажаар 0.55%, ширхэг хоорондын зай 45.5-49.0% дундажаар 47.2%, элэгдэл 27.2-30.6% дундажаар 28.9%, сульфат (хүйтэн тэсвэрлэлт) тэсвэрлэлт 3.14-3.47% дундажаар 3.30% байна.

Урвалжих чадварын хувьд дайрган дахь уусдаг цахиур (SiO₂)-ийн агууламж 40.2-43.33 ммоль/л дундажаар 41.8 ммоль/л байгаа нь бетонд хор нөлөөгүй ангилалд багтаж байна.

Ордын чулууны элэгдэх чанар нь 27.2-30.6%-д хэлбэлзэх ба дундажаар 28.9% байна. Энэ нь ордын барилгын чулуугаар дангаар нь шигтгэмэл зам талбай засах, автозамын далангийн 1-р үеийн хатуу хучаасаар ашиглах боломжгүй түүнийг бутлаж дайрга бэлтгэн зөвхөн хүнд бетон эдэлхүүн үйлдвэрлэх боломжтойг харуулж байна.

6. Шинжилгээ, туршилтуудын дүнгээр Баруун туруун-2 ордын барилгын чулуугаар бэлтгэсэн дайрга нь чанарын хувьд хүнд бетон эдэлхүүний түүхий эдийн шаардлагад бүрэн тохирч /MNS-2803-2004/ стандартын шаардлагыг бүрэн хангаж байна. Иймд

Баруун туруун-2 ордын барилгын чулуугаар дайрга бэлтгэж түүгээр 400 хүртэл маркийн барилгын хүнд бетон эдэлхүүн үйлдвэрлэж болно.

Энэ нь уг ордын дайрганы дээжээр хийсэн бетоны найрлага тогтоох туршилтаар батлагдаж байна.

Дайрганы хүйтэн тэсвэрлэлт (сульфат тэсвэрлэлт)-ийг хүхэр хүчлийн натрийн уусмалаар хөлдөөх гэсгээх аргаар БАК-ийн лабораторид тодорхойлсон ба уг ордын 10-20 мм, 20-40 мм хэмжээтэй дайргыг 15 удаа хөлдөөж гэсгээхэд жингийн алдагдал нь 3.14-3.47% (техникийн шаардлагаар жингийн алдагдал нь 5%-оос ихгүй байх ёстой) буюу хүйтэн тэсвэрлэлтээрийн 150-200 циклийг дааж байгаа нь уг ордын чулуугаар бэлтгэсэн дайргыг ашиглан үйлдвэрлэсэн хүнд бетон эдэлхүүн нь хүйтэн тэсвэрлэлт өндөртэй болохыг харуулж байна.

Ордын барилгын чулууны химийн найрлагыг 2 дээжийн шинжилгээгээр тогтоосон ба SiO_2 -ын агуулга 73.86-73.97% дундажаар 73.92%, Al_2O_3 -ын агуулга 9.96%, Fe_2O_3 -ын агуулга 0.98-1.2% дундажаар 1.09%, CaO -ын агуулга 1.16-1.38% дундажаар 1.27%, MgO -ын агуулга 1.28-1.92% дундажаар 1.6%, K_2O -ын агуулга 5.0-5.5% дундажаар 5.25%, Na_2O -ын агуулга 3.6-3.8% дундажаар 3.7%, SO_3 –ын агуулга 0.21-0.26% дундажаар 0,24%, ш.ү.а 2,55-2.65% дундажаар 2,60% байна.

Химийн найрлагын хувьд дайрга нь бетоны түүхий эдийн шаардлагыг хангаж байгаа ба чулуун дахь хүхэрлэг нэгдлийн хэмжээ нь бага дундажаар 0,24 % байна.

Цацраг идэвхижлийн судалгаагаар энэ ордын чулуун дахь радийн эквивалент нь 108.2-130.4 Бк/кг, дундажаар 122.13 Бк/кг байгаа нь барилгын материалд түүний зөвшөөрөгдөх хэмжээ 370 Бк/кг-аас 3 дахин бага байгаа нь түүгээр барилгын төрөл бүрийн бетон хийц үйлдвэрлэхэд бүрэн тохирох ба эрүүл ахуйн ямар нэг сөрөг нөлөөлөл байхгүй.

7. В-I блокийн талбайн урт тал нь 259 м, өргөн тал нь 310 м, түүний талбай S_1 -73990,7 м² ашигт малтмалын нөөц бодсон дундаж зузаан нь-16,5 м, дайрганы нөөц V-1 220 846,55м³, хуулах хөрсний дундаж зузаан-2,5 м, хуулах хөрсний эзэлхүүн V- 184 976.75 м³, хуулга хөрс, ашигт малтмалын харьцаа 1:6,6 байна.

Ордын дайрганы нийт бодитой (В) нөөц нь 1035033.7м³ гэж тооцоолсон байна.

Дайрганы нөөцийг хайгуулын тусгай зөвшөөрлийн 8 га талбайд нөөц бодсон тул цаашид талбайн хэмжээнд нөөц өсгөх боломжтой.

Шинжээч нөөцийн тооцоонд хяналтын хэмжилт, тооцоо хийж, зохиогчийг цэвэр шаврын нөөц бодохыг санал болгож бодсоныг зохиогч зөвшөөрч тооцоолсон ба ЭБМЗ-ийн хуралдааны үед гишүүдийн олонхийн саналаар ордын нөөцийг шинжээчийн тооцоолсон бодитой (В) нөөцийг 1221000.0 м³ -ээр хүлээн авч, ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэхийг зүйтэй гэж үзэв.

8. Баруун туруун-2 ордын барилгын чулууны хайгуулын малталтуудад хөрсний ус илрээгүй, учир барилгын чулууг олборлох үед гидрогеологийн хувьд онцын хүндрэлгүй

гэж үзсэн ба орд газрыг ашиглах үеийн унд-ахуйн усны хэрэгцээг ойролцоох гүний худгаас шийдвэрлэнэ гэж үзжээ.

9. Энэ ордыг ашиглах техник-эдийн засгийн урьдчилсан үнэлгээгээр 504,986 мян.м³ хөрс хуулах, 5 жилд 612,5 мян.м³ дайрга олборлох, 704,0 сая.төгрөгийн хөрөнгө оруулах, борлуулалтын нийт орлого 6125,0 сая төг, ашиглалтын зардал 3622,03 сая.төг, цэвэр ашиг 1481,256 сая.төг, 1 м³ дайрганы өөрийн өртөг 7581,0 төгрөг, хөрөнгө оруулалтаа 1.5 жилийн дотор нөхөх боломжтой байхаар тооцоолжээ.

10. Байгаль орчныг нөхөн сэргээх, нөлөөллийг бууруулах, хамгаалах, урьдчилан сэргээх зардалд 48 сая.төг төлөвлөсөн байна.

11. Орд газрын ашиглахын өмнө түүнийг ашиглахтай холбогдсон байгаль орчны үнэлгээнүүдийн болон ус ашиглуулах дүгнэлтийг холбогдох газруудаар гаргуулах, ашиглалтын ТЭЗҮ-ийг үндэслэлтэй боловсруулах, орд газрыг ашиглах үед ашиглалтын хайгуулыг зохих ёсоор хийх замаар эрсдлээ аль болохоор багасгаж ажиллах, байгаль орчныг нөхөн сэргээхэд онцгой анхаарч, Монгол улсын хууль тогтоомж, дүрэм журмыг баримталж ажиллахыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид анхааруулахаар тогтов.

Нөөцийн тооцоонд хийсэн шинжээчийн дүгнэлт, ЭБМЗ-ийн гишүүдийн саналыг үндэслэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаас гаргаж буй дараахь төслийн дагуу шийдвэр гаргахыг Ашигт малтмалын газрын даргад уламжлахаар шийдвэрлэв.

1. "Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн нутагт орших Баруун туруун-2-ын барилгын чулууны ордод 2010 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайлан" (Ордын нөөц 2011.01.01-ний байдлаар) дахь барилгын чулууны бодитой (В) зэргийн нөөцийг 1221000.0м³ -ээр шинжээчийн тооцоолсон хувилбараар, хавсралтын дагуу хүлээн авах;

2. Хуралдааны энэхүү дүгнэлтийн дагуу хүлээн авсан барилгын чулууны нөөцийг ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэхийг Геологи, мэдээллийн тасаг (Г.Алтанхуяг)-т зөвшөөрөх;

3. Баруун туруун-2 барилгын чулууны ордын дээрхи нөөцөд тулгуурлан, уг ордын дайргыг ашиглах техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах боломжтой гэж үзэх;

4. Энэхүү дүгнэлтийн 10, 11-д заасан зүйлийг цаашдын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг "Монфрукт" ХХК (Я.Ган-Эрдэнэ)-д анхааруулах;

5. Хайгуулын ажлын үр дүнгийн тайланг, хээрийн судалгааны анхдагч материал, тайлангийн бичвэрийн дискийн хамт ЭБМЗ-ийн хуралдааны энэхүү дүгнэлт, түүний дагуу гаргасан АМГ-ын даргын тушаалыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Геологи, мэдээллийн тасагт хүлээлгэн өгөхийг "Монфрукт" ХХК (Я.Ган-Эрдэнэ)-д даалгах;

6. Шийдвэрийн 5-д заасан үүргийг хэрэгжүүлээгүй тохиолдолд үйл ажиллагааг нь түдгэлзүүлүүлэх хүртэл арга хэмжээ авахыг “Монфрукт” ХХК (Я.Ган-Эрдэнэ)-д анхааруулах;

7. Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн нутагт орших Баруун туруун-2-ын барилгын чулууны ордод 2010 онд гүйцэтгэсэн хайгуулын ажил, түүний бүх төрлийн дээжлэлт, тайлан боловсруулалтыг геологич У.Энхтайван, физик механикийн хураангуй, бүрэн, лаборатори-технологи-бетоны найрлага тогтоох, лаборатори-технологи-бетоны найрлага тогтоох шинжилгээнд ашигласан элсний физик-механикийн, лаборатори-технологи-бетоны найрлага тогтоох шинжилгээнд ашигласан цементийн, урвалжих чадвар, хүйтэн тэсвэрлэлтийн, химийн, рентгендифрактометрийн, барилгын чулууны элэгдлийн шинжилгээний үр дүнг тус тус Барилга Архитектурын лаборатори, цацраг идэвхижлийн шинжилгээний үр дүнг Цөмийн судалгааны төв, 1:2000 масштабтай байр зүйн зураглал “Жи Ди Эс Эс” ХХК хариуцах, дээрхи гүйцэтгэсэн ажлуудын үнэн бодит байдал, чанарыг хянаж гаргасан дүгнэлтийг МУ-ын зөвлөх инженер, геологич С.Алтангэрэл, МУ-ын барилгын материалын зөвлөх инженер О.Лхагвадорж, Н.Оч нар тус тус хариуцах.

ТАНИЛЦСАН:

ЭБМЗ-ИЙН ДАРГА,
ЭБЭХЯ-НЫ ГБГ-ЫН ДАРГА



Ө.ОЮУНБААТАР

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:

ЭБМЗ-ИЙН ОРЛОГЧ ДАРГА,
АМГ-ЫН ГУУА-НЫ ДАРГА


М.АРИУНБАЯР

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА


Г.НАРАНЦЭЦЭГ

ЭБМЗ-ийн 2011
оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 07
дугаар хуралдааны ХХ-07-04 дүгээр
дүгнэлтийн хавсралт


Баруун туруун-2 дайрганы ордын нөөцийн тооцооны нэгдсэн хүснэгт

Нөөцийн блок, дугаар	Нөөцийн планы масштаб	Нөөцийн зэрэг	Нөөцийн блокуудын талбай, м ²			Ашигт малтмалын нөөц, м	
			Зохиогчийн хувилбараар	Шинжээчийн хувилбараар	Зөрөө +-	Зохиогчийн хувилбараар	Шинжээчийн хувилбараар
В-I	1:1000	Бодитой (В)	73990,7	74000,0	+9,3	1035033,7	1221000,0
Бодитой (В) нөөц бүгд:						1035033,7	1221000,0

Тооцоолсон: Шинжээч С.Алтангэрэл



Э.ТАМИР



Л.БАЯРМАНДАЛ

“БАРУУН ТУРУУН-2” БАРИЛГЫН ЧУЛУУНЫ ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ /ТОДОТГОЛ-1/

ТАНИЛЦСАН:

ЭБМЗ-н салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга *Б.Хулан* **Б.ХУЛАН**

ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАГЧ: “ЭРДЭНЭС ИНЖЕНЕРИНГ” ХХК-ийн

Төслийн удирдагч,

Монгол улсын зөвлөх инженер

Б.Баяраа **Б.Баяраа**

Төслийн зөвлөх, Монгол улсын зөвлөх инженер

С.Дэлгэрдалай **С.Дэлгэрдалай**

Уулын инженер

Н.Даваасүрэн **Н.Даваасүрэн**

Уулын инженер

С.Сэргэлэн **С.Сэргэлэн**

Уулын инженер

С.Буяндэлгэр **С.Буяндэлгэр**

Эдийн засагч


А.Туяагэрэл **А. Туяагэрэл**

GIS-ийн инженер

Б.Алтанзагас **Б.Алтанзагас**

ТӨСЛИЙН ШИНЖЭЭЧ:

Монгол улсын зөвлөх инженер



Д.Түмэннасан **Д.Түмэннасан**



АШИГТ МАЛТМАЛ,
ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 08 сарын 14 өдөр

Дугаар Т/86

Улаанбаатар хот

Техник, эдийн засгийн үндэслэл
хүлээн авах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалт, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн Т/23-06-02 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн нутагт орших Монфрукт ХХК-ийн MV-016848 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Баруун туруун-2” нэртэй барилгын чулууны ордыг ил аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийн тодотгол-1-ийг хүлээн авсугай.

2. Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн нутагт орших Монфрукт ХХК-ийн MV-016848 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Баруун туруун-2” нэртэй барилгын чулууны ордыг ил аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийн тодотгол-1-ийг хуулсан дискийг төсөл эзэмшигчээс хүлээн авахыг Уул уурхайн хэлтэс (Т.Зууннаст)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Л.БАЯРМАНДАЛ



53710851



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН
ДҮГНЭЛТ

2023 оны 06 дугаар сарын 04

№ 7/23-06-02

Улаанбаатар хот

Улаанбаатар хотын
Сонгинохайрхан дүүргийн нутагт
орших MV-016848 тоот
ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй
“Баруун туруун-2” нэртэй барилгын
чулууны ордыг ил аргаар ашиглах
техник, эдийн засгийн үндэслэлийн
тодотгол-1-ийг хэлэлцсэн тухай

Монфрукт ХХК-ийн захиалгаар Уул уурхайн зураг төслийн Эрдэнэс инженеринг ХХК боловсруулсан Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн нутагт орших “Баруун туруун-2” нэртэй барилгын чулууны ордыг ил аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийн тодотгол-1-д Монгол Улсын зөвлөх инженер С.Дэлгэрдалай зөвлөж, Монгол Улсын зөвлөх инженер Д.Түмэннасан шинжээчийн дүгнэлт гаргасан байна. Техник, эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн ашигт малтмалын орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэл хэлэлцэх салбар хуралдаанаар авч хэлэлцэж, дараах ДҮГНЭЛТ-ийг гаргаж байна.

1. Энэхүү техник, эдийн засгийн үндэслэл нь Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2012 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 074-р тушаалаар баталсан “Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник, эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник, эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам”-ын дагуу гүйцэтгэгдсэн байна гэж үзлээ.
2. Техник, эдийн засгийн үндэслэлийн тодотгол нь уншихад ойлгомжтой, цэгц дараалал сайтай, мэргэжлийн түвшинд чанартай сайн боловсруулсан, уурхайг эхлэн байгуулж үйлдвэрлэл явуулах бүх шат дамжлага буюу үйл ажиллагааг хамарсан, ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах үндсэн баримт бичиг болжээ.
3. Техник, эдийн засгийн үндэслэл нь Геологийн хэсэг, Уул технологийн хэсэг, Бутлан ангилах технологи, Дэд бүтэц, Уурхайн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, Уурхайн хаалтын төлөвлөлт байгаль хамгаалах нөхөн сэргээх, Эдийн засгийн үр ашиг зэрэг 8 бүлэг, дүгнэлт, хавсралт материал, тооцоо бүхий 133 хуудас тайлбар бичиг, 14 хавсралт зургуудаас бүрдэж байна.
4. Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн нутагт орших “Баруун туруун-2” барилгын чулууны ордод 2010 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн үндэслэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2011 оны 04 дүгээр сарын 15-ны

өдрийн ХХ-07-04 тоот дүгнэлтийг үндэслэн гаргасан Ашигт малтмалын газрын даргын 2011 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 185 тоот тушаалаар бодитой (В) зэрэглэлээр 1,221,000.0 м³ гэж ашигт малтмалын улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна. “Баруун туруун-2” барилгын чулууны ордын 2 дугаар хэсэгт 2022 онд гүйцэтгэсэн нэмэлт хайгуулын ажлын үр дүнгийн үндэслэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн ХХ-14-01 тоот дүгнэлтийг үндэслэн гаргасан Үндэсний геологийн албаны даргын 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн Н-95 тоот тушаалаар бодитой (В) зэрэглэлээр 950,603.3 м³, боломжтой (С) зэрэглэлээр 736,840.00 м³—ээр, нийт бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр 1,687,443.3 м³ гэж ашигт малтмалын улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна.

5. Төсөлд Ил уурхай-1-ийн ашиглалтын үеийн бохирдол 1.02% буюу 11.1 мян.м³, хаягдал 0.67% буюу 7.4 мян.м³, нийт дайрганы тэсэлгээний үеийн хаягдал 1.0% буюу 11.0 мян.м³, нийт 1.67% хаягдал нөөцөөс хасагдаж байхаар тооцож геологийн бодитой (В) зэрэглэлийн нөөцийг үйлдвэрлэлийн магадалсан В' нөөцөд шилжүүлэн тооцооноор үйлдвэрлэлийн нөөц 1,082,561.7 м³ дайрга байна.

Ил уурхай-2-ын ашиглалтын үеийн бохирдол 0.82% буюу 13.9 мян.м³, хаягдал 0.08% буюу 1.4 мян.м³ нийт дайрганы тэсэлгээний үеийн хаягдал 1.0% буюу 17.0 мян.м³, нийт 1.08% хаягдал нөөцөөс хасагдаж байхаар тооцож геологийн бодитой (В) зэрэглэлийн нөөцийг үйлдвэрлэлийн магадалсан В' нөөцөд шилжүүлэн тооцооноор үйлдвэрлэлийн нөөц 1,682,951.4 м³ дайрга байна.

Нийт уурхайн нөөц 2,765,513.1 м³, жилд 500 мян.м³ элс олборлох хүчин чадлаар нийт үйлдвэрлэлийн нөөцийг 6 жилийн хугацаанд ашиглахаар төлөвлөсөн байна.

6. Ил уурхайн ашиглалтын системийн сонголтыг хийхдээ ордын уул геологийн тогтоц, нөхцөл, хүдрийн биетийн хэлбэр, хэмжээ, жилд хийгдэх нийт уулын цулын эзлэхүүн зэрэг мөн гүн их биш, уул-геологийн нөхцөл харьцангуй энгийн тул ил уурхайн гадаад овоолго бүхий авто тээвэртэй ашиглалтын системээр ашиглах нь хамгийн тохиромжтой гэж үзэж олборлохоор тооцсон байна.

7. Ил уурхайн өрөмдлөг тэсэлгээний ажилд Jk358h маркийн өрмийн машин, хөрс, элс ухаж ачих ажилд Hyundai-300 LC маркийн экскаватор 2 ширхэг, хөрс, элс тээвэрт Shacman маркийн автосамосвал 4 ширхэг, хөрсний овоолго дээр түрж тараах, тэгшлэх ажилд ZL-50 маркийн утгуурт ачигч сонгосон байна. Бутлан ангилах үйлдвэрт хүлээн авах бункер 1 ширхэг, Qh-1042 маркийн чичиргээт тэжээгч 1 ширхэг, Fsk-3020 маркийн хацарт бутлуур 1 ширхэг, Mc-200 (a) маркийн конусан бутлуур 1 ширхэг, Mc-200 (b) маркийн конусан бутлуур 1 ширхэг, Op-1842 чичиргээт шигшүүр 1 ширхэг, Op3-2160 маркийн чичиргээт шигшүүр 1 ширхэг, B1000 маркийн туузан конвейер 1 ширхэг, B800 маркийн туузан конвейер 1 ширхэг, B650 маркийн туузан конвейер 1 ширхэг, DMC-144A маркийн тоос барих төхөөрөмж 1 ширхэг сонгосон байна.

8. Технологийн туршилтыг 2010 онд Барилга Архитектур Корпорацын Барилгын материал технологийн судалгааны төвийн лабораторид гүйцэтгүүлсэн байна. Дайрга бутлан ангилах үйлдвэр нь анхдагч хүдрийг -100 мм хүртэл 3-шатны бутлалт, 2-шатны хяналтын шигшилттэй схемээр буталж ангилах бөгөөд жилд 500.0 мян.м³ дайрга бутлан ангилж 62.5 мян.м³ элс, 125.0 мян.м³ хайрга, 250.0 мян.м³ дайрга гарган авах буюу төслийн хугацаанд нийт 2,765.5 мян.м³ дайрга олборлон, бутлан ангилж 345.7 мян.м³ элс, 691.4 мян.м³ хайрга, 1,382.8 мян.м³ дайрга үйлдвэрлэхээр тооцжээ.

9. Төсөлд Найрамдал дэд станцаас татсан AC-50 маркийн дамжуулагч утастай 10 кВ-н цахилгаан дамжуулах өндөр хүчдэлийн агаарын шугамд 1 дүгээр

Үйлдвэрийн хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангаж байгаа 10/0.4 кВ-н 630 кВА номеналь бүрэн чадалтай хүчний трансформатор бүхий трансформаторын иж бүрэн дэд станц өнөөгийн байдлаар ашиглаж байна. Уг төсөлд 10/0.4 кВ-н 630 кВА номеналь бүрэн чадалтай хүчний трансформатор бүхий трансформаторын иж бүрэн дэд станц 2 ширхгийг нэмж холбохоор тооцоолжээ. Төслийн хугацаанд 14.82 мян.м³ ус ашиглах бөгөөд үүнээс унд ахуйн хэрэглээнд 9.12 мян.м³, технологийн усны хэрэглээнд 5.7 мян.м³ тус тус байгаа бөгөөд өөрийн эзэмшлийн худагас хангахаар төлөвлөжээ.

10. Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлт ба хаалтын зардалд нийт 1,106.2 сая төгрөг зарцуулахаар тооцсон байна. Үүнээс техникийн нөхөн сэргээлтийн зардалд 651.7 сая төгрөг, биологийн болон дүйцүүлэн нөхөн сэргээлтийн зардалд 349 сая төгрөг, мониторингийн зардалд 10.1 сая төгрөг, хаалтын зардалд 95.4 сая төгрөг тус тус зарцуулахаар тусгажээ.

11. Уг төслийг хэрэгжүүлснээр 80 орчим хүн ажлын байраар хангагдах ба уурхайн ажилчдын сарын дундаж цалин 2,645 мян.төг байхаар байна.

12. Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн нутагт орших “Баруун туруун-2” нэртэй барилгын чулууны ордыг ил аргаар ашиглах төсөл хэрэгжүүлэхэд нийт 3,398.1 сая төгрөг, үүнээс шинээр хийх 1,700.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай байна. Үүнээс ил уурхайн техник, тоног төхөөрөмж 1690.5 сая төгрөг, дэд бүтцийн барилга, байгууламж 265.7 сая төгрөг, бутлан ангилах үйлдвэр 1909.2 сая төгрөг, цахилгаан, усан хангамж 489.9 сая төгрөг, байхаар тооцжээ. Элэгдэл хорогдлын шимтгэлийн зардалд нийт 1,404.1 сая төгрөг байхаар тооцоолсон байна.

13. Уурхайг ашиглах төслийн 6 жилийн хугацаанд үндсэн хөрөнгийн үлдэгдэл болон борлуулалтын нийт 37.4 тэрбумын орлого олж, 32.4 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны зардал гарган, 4.9 тэрбумын төгрөгийн татварын өмнөх ашигтай ажиллахаар байна. Татвар ногдуулсны дараах байдлаар нийт 4.4 тэрбумын төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар байна. Улс, орон нутгийн төсөвт 8.6 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр тусгажээ. Уурхайн ашиглалтын хугацаанд 1 м³ дайрганы бүрэн өөрийн өртөг 11.7 мян.төг байна.

14. Төсөл хэрэгжих хугацаанд нийт 4.6 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны мөнгөн урсгал бий болох ба хорогдуулалтын нормыг жилийн 10 хувиар тооцоход төслийн өнөөгийн үнэ цэнэ (NPV,@10%) 2.9 тэрбум төгрөг, дотоод өгөөжийн норм (IRR) 21%, хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа 1.6 жил байхаар тооцжээ.

Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс техник, эдийн засгийн үндэслэлийн захиалагч, боловсруулагч болон төслийн шинжээчид дараах асуудлыг анхааруулж байна. Үүнд:

1. Төсөл захиалагч нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн А/205 тоот тушаалаар баталсан Баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журмын дагуу үйл ажиллагаа явуулах;
2. Төсөл захиалагчид Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/181, А/458 тоот тушаалаар батлагдсан Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журмын дагуу Хаалтын менежментийн төлөвлөгөөг боловсруулж холбогдох байгууллагаар хэлэлцүүлэн, уурхайн хаалт, нөхөн сэргээлт хийх;

3. Төсөлд шаардлагатай мэргэжлээр Монгол Улсын иргэдийг бэлтгэх, тэдгээрийг ажлын байраар хангах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж ажиллах;
4. Техник, эдийн засгийн үндэслэлд тусгагдсан техник, технологийн сонголт, уулын ажлын төлөвлөлт, цахилгаан хангамж, дэд бүтцийн сонголт, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шийдлийн талаар төслийн эдийн засгийн үнэлгээг боловсруулсан Уул уурхайн зураг төслийн Эрдэнэс инженеринг ХХК, мөн түүний үнэн бодит байдал, чанарт дүгнэлт гаргасан Монгол Улсын зөвлөх инженер Д.Түмэннасан шинжээч тус тус хариуцах.

Техник, эдийн засгийн үндэслэлд хийсэн шинжээчийн дүгнэлт, зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Салбар хуралдаанаас Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4, 48 дугаар зүйлийн 48.4, Газрын хэвлийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгүүд болон энэ дүгнэлт, холбогдох хуулийн заалтуудыг тус тус үндэслэн дараах шийдвэр гаргахыг Ашигт малтмал, газрын тосны газрын даргад уламжлахаар тогтов.

1. Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн нутагт орших MV-016848 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Баруун туруун-2” нэртэй барилгын чулууны ордыг ил аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийн тодотгол-1-ийг хүлээн авах;
2. Техник, эдийн засгийн үндэслэлд тусгасан уурхайн хүчин чадал, техник тоног төхөөрөмж, технологи, эдийн засгийн тооцоог өөрчлөх тохиолдолд уг техник-эдийн засгийн үндэслэлд тодотгол хийлгэж Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн салбар хуралдаанаар хэлэлцүүлж байхыг төсөл хэрэгжүүлэгчид анхааруулах;
3. Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн нутагт орших MV-016848 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Баруун туруун-2” нэртэй барилгын чулууны ордыг ил аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийн тодотгол-1, түүнийг хуулсан диск, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийн хамт Геологийн баримтын төв архивд холбогдох шаардлагад нийцүүлэн хүлээлгэн өгөх арга хэмжээг авах.

ТАНИЛЦСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН ОРЛОГЧ ДАРГА

Л.БАЯРМАНДАЛ

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР
ХУРАЛДААНЫ ДАРГА

М.МЭНДБАЯР

БОЛОВСРУУЛСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ХУРАЛДААНЫ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

ТУС А 0810

Б.ХУЛАН

УЛААНБААТАР ХОТЫН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН НУТАГТ ОРШИХ БАРУУН ТУРУУН-2 БАРИЛГЫН ЧУЛУУНЫ
ОРДЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН НӨӨЦИЙН ТООЦООНЫ НЭГТГЭЛ /MV-016848/

ЭБМЗ-ийн... дугаар дүгнэлтийн хавсралт
Хүснэгт 1

Блокын дугаар	Геологийн нөөц					Олборлосон нөөц	Үйлдвэрлэлийн нөөцийн зэрэг	Ил уурхайн нөөц	Хаягдал, бохирдол			Ашиглалтын нөөц	
	Блокын талбай, м ²	Хуулах хөрсний зузаан, м	Ашигт малтмалын зузаан, м	Хуулах хөрсний эзэлхүүн, мян.м ³	Ашигт малтмалын нөөц, мян.м ³				Хаягдал 1.40%				Хажуугийн бохирдол 0.21%
									Хаягдал таазнаас, 10см	Тасалганы үеийн хаягдал, 1%	Эзлэхүүн дайрга, мян.м ³		
Уурхай-2 /2022/													
B-I	4360.6	17.97	218.00	78.371	950.603	B-I'	950.603	436.06	9553.91	9.99	4.79	945.40	
C-I	566.5	48.47	208.00	27.456	117.832	B-I'	117.832	56.65	1202.93	1.26	2.46	119.03	
C-II	966.2	28.07	240.00	27.120	231.888	B-II'	231.888	96.62	2345.10	2.44	2.62	232.07	
C-III	8065.0	7.14	48.00	57.600	387.120	B-III'	387.120	806.50	3911.67	4.72	4.05	386.45	
Боломжтой /C/	9597.7	11.69	76.77	112.176	736.840		736.840	959.770	7459.695	8.419	9.13	737.55	
/B+C/	13958.3	13.65	120.89	190.547	1687.443		1687.443	1395.83	17013.61	18.41	13.92	1682.95	
Уурхай-1 /2020/													
B-I	7399.7	25.00	165.01	184.977	131.135	B-I'	1089.87	7399.07	11009.71	18.41	11.1	1082.56	
Ордны хэмжээнд													
Бодитой /B/	11760.3	22.39	184.66	263.348	2171.603		2040.468	7835.13	20563.62	28.40	15.89	2027.96	
Боломжтой /C/	9597.7	11.69	76.77	112.176	736.840		736.840	959.77	7459.70	8.42	9.13	737.55	
/B+C/	21358.0	17.58	136.18	375.524	2908.443		2777.308	8794.9	28023.31	36.82	25.02	2765.5	

*ЭБМЗ-ийн 2011 он 04-р сарын 15-ний өдрийн ХХ-07-04 тоот дүгнэлтээр Баруун туруун-2 барилгын чулууны ордны хэмжээнд геологийн В зэргийн нөөц 1221.51 мян.м³ дайрга хүлээн авсан байна. 2020.01.01-ны байдлаар геологийн нийт үлдэгдэл нөөц 1089.87 мян.м³ дайрга байна. MV-016848 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Баруун туруун-2 ордны бодитой В нөөцийг Уул уурхайн сайдын 2015 оны 09-р дүгээр сарын 11-ний өдрийн 203 тоот "Ашигт малтмалын баялаг, ордны нөөцийн ангилал, заавар" тушаалын дагуу үйлдвэрлэлийн магадалсан (B') нөөц болголоо. Ашиглалтын үеийн бохирдол, хаягдал тооцсон уурхайн үйлдвэрлэлийн нийт нөөц 1082.56 мян.м³ дайргыг уурхай 1-ээс олборлохоор ТЭЗҮ-ийн тооцоог хийлээ.

*ЭБМЗ-ийн 2022 он 09-р сарын 22-ний өдрийн ХХ-14-01 тоот дүгнэлтээр Баруунтуруун-2 барилгын чулууны ордны 2-р хэсгийн хэмжээнд геологийн В зэргийн нөөц 950.6 мян.м³ дайрга, С зэргийн нөөц 736.84 мян.м³ дайрга, В+С зэргийн нөөц 1,687.443 мян.м³ дайрга хүлээн авсан байна. MV-016848 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Баруун туруун-2 барилгын чулууны орд нь хэлбэр, хэмжээ, тогтоцон онцлог, хүдрийн тархалт зэргийг харгалзан ордны нийлмэл байдлын ангиллын дагуу II бүлэгт хамаарч байгаа учир бодитой В болон боломжтой С нөөцийг Уул уурхайн сайдын 2015 оны 09-р дүгээр сарын 11-ний өдрийн 203 тоот "Ашигт малтмалын баялаг, ордны нөөцийн ангилал, заавар" тушаалын дагуу үйлдвэрлэлийн магадалсан (B') нөөц болголоо. Ашиглалтын үеийн бохирдол, хаягдал тооцсон уурхайн үйлдвэрлэлийн нийт нөөц 1682.95 мян.м³ барилгын чулууг уурхай 2-оос олборлохоор ТЭЗҮ-ийн тооцоог хийлээ.



Нөөцийн тооцоог хийсэн: "Эрдэнэс Инженеринг" ХХК-ийн инженер **ИНЖЕНЕРИНГ.Б.Алтанзагас**



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 04 сарын 03 өдөр

Дугаар 7/107.

Улаанбаатар хот

Техник-эдийн засгийн үндэслэл
хүлээн авах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэг, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2020 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн т/20-07-17 тоот дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн нутагт орших MV-016848 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Монфрукт ХХК-ийн Баруун туруун-2 нэртэй барилгын чулууны ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэл /тодотгол/-ийг хүлээн авсанд тооцсугай.

2. Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн нутагт орших MV-016848 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Баруун туруун-2 нэртэй барилгын чулууны ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэл /тодотгол/-ийг диск, ЭБМЗ-ийн дүгнэлтийн хамт энэхүү тушаалыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төвийн Геологийн баримтын төв архивт хүлээлгэн өгөхийг Монфрукт ХХК-д даалгасугай.

ДАРГА

Х.ХЭРЛЭН

53780071



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН
ДҮГНЭЛТ

2020 оны 05 сарын 26 өдөр

Дугаар Т/20 - 07-17

Улаанбаатар хот

Улаанбаатар хотын
Сонгинохайрхан дүүргийн нутагт
орших MV-016848 тоот тусгай
зөвшөөрлийн дугаар бүхий Баруун
туруун-2 барилгын чулууны ордыг
ил аргаар ашиглах техник-эдийн
засгийн үндэслэлийн тодотголыг
хэлэлцсэн тухай

“Монфрукт” ХХК-ийн захиалгаар Уул уурхайн зураг төслийн “Майнинг шорт лонг терм” ХХК боловсруулсан Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн нутагт орших Баруун туруун-2 барилгын чулууны ордыг ил аргаар ашиглах техник эдийн засгийн үндэслэлийн тодотголд Монгол улсын уул уурхайн зөвлөх инженер Л.Жаргалсайхан зөвлөж, шинжээч мэргэшсэн инженер Д.Тунгалаг шинжээчийн дүгнэлт гаргасан байна. Техник-эдийн засгийн үндэслэлийн тодотголыг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн ТЭЗҮ хэлэлцэх салбар хуралдаанаар авч хэлэлцэж, дараах ДҮГНЭЛТ-ийг гаргаж байна.

1. Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн нутагт орших Баруун туруун-2 барилгын чулууны ордыг ил аргаар ашиглах техник эдийн засгийн үндэслэлийн тодотгол нь Оршил, Ордын геологи, Уурхайн үйлдвэрлэлийн нөөц, Уурхайн жилийн хүчин чадал ба ажиллах горим, ашиглалтын хугацаа, Уурхайн өнөөгийн байдал ба ашиглах дараалал, Өрөмдлөг-тэсэлгээний ажил, Ашиглалтын систем, Уурхайн тээвэр, Овоолгын аж ахуй, Бутлан ангилах хэсэг, Уурхайн дэд бүтэц, Уурхайн удирдлага, зохион байгуулалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, Байгаль орчин, нөхөн сэргээлт, Эдийн засгийн тооцоо гэсэн 14 бүлэг 152 хуудас тайлбар бичиг болон 9 ширхэг хавсралт зураг бусад хавсралт материалуудаас бүрдсэн байна.

2. Тус орд нь MV-016848 тоот тусгай зөвшөөрлийн талбайн нөөцийг ЭБМЗ-ийн 2011 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдааны ХХ-07-04 дүгээр дүгнэлт, Ашигт малтмалын газрын Даргын 2011 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн Н/185 дугаар тушаалаар бодитой (В) зэрэглэлээр 1,221,000.0 м³-ээр бүртгэсэн байна.

3. Төсөлд үйлдвэрлэлийн нөөцийг бодохдоо ашиглалтын үеийн хаягдал 5.7%-аар (68,400 м³), бохирдол 0.6%-аар (7,200 м³), тооцоход уурхайн хүрээнд 1,121,500.0 м³ байна. Орд нь 1 блокоос бүрдэх ба хөрс дунджаар 2.5м хүртэл

бөгөөд тус блокыг авто тээвэртэй, гадаад овоолго үүсгэн ашиглана. Ордыг 5 жилийн хугацаанд 1,121,500 м³ барилгын чулуу бутлан ангилах хэсэгт нийлүүлнэ. Жилийн хүчин чадал 250.0 мян.м³ бөгөөд хөрс хуулалтын дундаж итгэлцүүр 0.15 м³/м³ байна.

4. Бутлан ангилах хэсэг нь жилд 250.0 мян.м³ барилгын чулуу бутлан ангилах хүчин чадалтай байна. Төсөл хэрэгжих 5 жилийн хугацаанд нийт 1,121,500.0 м³ барилгын чулуу үйлдвэрлэхээр байна.

5. Ордын барилгын чулууг БНСУ-ын "Вон Дак" фирмийн бутлан ангилах үйлдвэрийн тоног төхөөрөмжөөр авахаар төлөвлөсөн байна.

6. Төслийн талбай дээрх үйлдвэр, объектууд болон цахилгаан тоног төхөөрөмжийг цахилгаанаар хангахын тулд УБЦТСүлжээний төвийн шугамд холбогдсон. 10/0.4кВа трансформатортай, уурхайн хэрэглээг 400кВа чадал бүхий трансформатороор уурхайн дотоод хэрэглээг хангана.

7. Ордын ашиглалтын хугацаанд нийт 41 хүний ажлын байр бий болж, 1 ажилтны сарын дундаж цалин 1.14 сая төг байна.

8. Төслийг хэрэгжүүлэгч "Монфрукт" ХХК нь байгаль орчин, нөхөн сэргээлтийн тухай Монгол улсын холбогдох хууль тогтоомж, стандартуудыг мөрдлөг болгон ажиллана. Байгаль орчин, хаалт, нөхөн сэргээх ажлын хэрэгжилтэд анхаарч ажиллахыг төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгжид анхааруулахаар тогтов. Үйлдвэрийн байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээх, мониторингийн зардалд нийтдээ ашиглалтын хугацаанд 204.4 сая төгрөг зарцуулахаар тусгажээ.

9. Уурхайн хөрөнгө оруулалт 798.6 сая төгрөг байна. 1 м³ барилгын чулууны бүрэн өөрийн 9,261.8 төгрөг байх ба төслийн хугацаанд нийт 10.22 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой байна. 8.45 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны зардалтай, татвар төлсний дараа 1.74 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар тооцоолсон.

10. Үйл ажиллагааны мөнгөн урсгалаас хөрөнгө оруулалтын зардлыг хассан ашгийг жилийн 9-15%-ийн дискаунтын (хорогдуулалт) нормоор бууруулан, өнөөгийн мөнгөнд шилжүүлсэн цэвэр ашгийг (NPV@9%) тооцвол 408.22 сая төгрөг. Төсөл нь хөрөнгө оруулалтаа 3 жилийн хугацаанд бүрэн нөхөх бөгөөд дотоод өгөөжийн норм (IRR%) 34% байна.

11. Төслийн хугацаанд нийт 1.16 тэрбум төгрөгийн татвар хураамжийг улс болон орон нутгийн төсөвт оруулна.

12. Төсөлд шаардлагатай мэргэжлээр Монгол улсын иргэдийг бэлтгэх, тэдгээрийг ажлын байраар хангах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж байгаль орчныг нөхөн сэргээх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байхыг ЭБМЗ-өөс даалгаж байна.

13. Техник, эдийн засгийн үндэслэлийн тодотгол нь уншихад ойлгомжтой, цэгц дараалал сайтай, мэргэжлийн төвшинд чанартай сайн боловсруулсан, үйлдвэрийн үйлдвэрлэл явуулах бүхий л шат дамжлага буюу үйл ажиллагааг хамарсан, угаах

үйлдвэрийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах зэрэгт туслах баримт бичиг болжээ.

14. Засгийн газрын 379-р тогтоолоор батлагдсан “Тусгай зориулалтын авто зам, замын байгууламж барих, ашиглах журам” – г тусгай зөвшөөрөл эзэмшигч компани нь мөрдөж ажиллахыг анхааруулж байна.

15. Энэхүү техник, эдийн засгийн үндэслэлийн тодотгол нь ЭБЭХ-ийн сайдын 2012 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 074-р тушаалаар баталсан “Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник, эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник, эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам”-ын дагуу гүйцэтгэгдсэн байна гэж үзлээ.

16. Техник-эдийн засгийн үндэслэлийн тодотголд тусгагдсан техник, технологийн сонголт, уулын ажлын төлөвлөлт, цахилгаан болон усан хангамж, дэд бүтэц, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, төслийн эдийн засгийн үнэлгээг боловсруулсан Уул уурхайн зураг төслийн “Майнинг шорт лонг” ХХК хариуцах, түүний үнэн бодит байдал, чанарт гаргасан дүгнэлтийг шинжээч мэргэшсэн инженер Д.Тунгалаг хариуцах.

17. Техник-эдийн засгийн үндэслэлийн тодотголд тусгасан уурхайн хүчин чадал, техник тоног төхөөрөмж, технологи, эдийн засгийн тооцоог өөрчлөх тохиолдолд уг техник-эдийн засгийн үндэслэлд тодотгол хийлгэж, ЭБМЗ-ийн салбар хуралдаанаар хэлэлцүүлж байх нь зүйтэй.

18. Захиалагч компани Техник-эдийн засгийн үндэслэлийн тодотголыг хүлээн авах тухай Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллагын шийдвэр гарснаас хойш 5 хоногт багтаан Техник-эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төвд холбогдох шаардлагад нийцүүлэн хүлээлгэн өгөх үүрэгтэй. Энэ үүргээ хэрэгжүүлээгүй тохиолдолд Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллагын дарга гаргасан шийдвэрээ түдгэлзүүлэх, цуцлах эрхтэйг анхааруулах нь зүйтэй.


Техник-эдийн засгийн үндэслэлийн тодотголд хийсэн шинжээчийн дүгнэлт, зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Салбар хуралдаанаас Ашигт малтмал, газрын тосны газрын даргад Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4, 48 дугаар зүйлийн 48.4, Газрын хэвлийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгүүд болон энэ дүгнэлт, холбогдох хуулийн заалтуудыг тус тус үндэслэн Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн нутагт орших Баруун туруун-2 барилгын чулууны ордыг ил аргаар ашиглах техник эдийн засгийн үндэслэлийн тодотголыг хүлээн авах шийдвэр гаргахыг уламжлахаар шийдвэрлэв.

ТАНИЛЦСАН:
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.МӨНХТӨР

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.ДЭЛГЭРЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН:
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Э.БОЛД-ЭРДЭНЭ

ЭБМЗ-ийн 7/20-07-17 дугаар дүгнэлтийн хавсралт

**УЛААНБААТАР ХОТЫН СОНГИНОХАЙРХАН ДУУРГИЙН НУТАГТ ОРШИХ МУ-016848 ТООТ ТУСГАЙ
ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР БУХИЙ
БАРУУН ТУРУУН-2 БАРИЛГЫН ЧУЛУУНЫ ОРДЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН НӨӨЦИЙН ТООЦОО**

Блокын дугаар	Геологийн батлагдсан нөөц			2011-2014 онд ашигласан геологийн нөөц			Үйлдвэрлэлийн нөөцийн дугаар		Хаягдал		Үйлдвэрлэлийн нөөцийн хэмжээ, мян.м ³							
	Талбай, мян.м ²	Зузаан, м	Нөөцийн хэмжээ, мян.м ³	Хөрө	Дайра	Хөрө	Хөрө	Дайра	Хөрө	Дайра	Хэмжээ, мян.м ³	Хувь	Хэмжээ, мян.м ³	Хувь				
В-1	74.00	2.5	16.5	185.00	1221.0	11.42	17.30	173.58	1203.7	Хөрө	Дайра	173.56	1200.00	5.7	68.4	0.6	7.2	1138.8
Дүн	74.00	2.5	16.5	185.00	1221.0	11.42	17.30	173.58	1203.7	Хөрө	Дайра	173.56	1200.00	5.7	68.40	0.6	7.20	1138.8

Тайлбар: Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн нутагт орших Баруун туруун-2 барилгын чулууны ордын нөөцийг 2011 оны 04-р сарын 15 өдөр хүлээж авсан ЭБМЗ-ийн ХХ-07-04 тоот дүгнэлтийн хавсралт тооцоо, АМГ-ын даргын 2011 оны 05 дугаар сарын 09-ны өдрийн 185 дугаар тушаалаар улсын бүртгэлд бүртгэсэн геологийн нөөц болон Уул уурхайн сайдын 2015 оны 09-р сарын 11-ний өдрийн 203 тоот тушаалын хавсралт “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, заавар”-ын тус тус үндэслэн тооцоог хийв. Тус орд нь II бүлэгт хамаарч байгаа тул үйлдвэрлэлийн нөөцийг тооцохдоо бодиттой В зэргийн нөөцийг магадласан В зэрэг нөөцөд шилжүүлэн тооцов. Уг ордыг ашиглах үед хаягдал нь 5.7%, бохирдолт нь 0.6% байхаар төлөвлөсөн ба ил уурхайн үйлдвэрлэлийн нөөц магадласан В зэргээр нийт 1138.8 мян.м³ байхаар тооцов.

Үйлдвэрлэлийн нөөцийн тооцоог хийсэн:

Уул уурхайн инженер

Б.Уранчимэг

Б.Уранчимэг

Батлав: МОНФРУКТ ХХК-ийн /~~УИЦЭТГЭХ~~
/АХИРАЛ /Э.ТАМИР/



Зөвшөөрсон: НИЙСЭЛЛИЙН АШИГЛАХ ОРШИНЫ
ГАЗРЫН ДАРГА /Н.МӨНХБАЯР/



**СОНГИНО-ХАЙРХАН ДҮҮРГИЙН 33-Р
ХОРООНЫ НУТАГТ ОРШИХ БАРУУНТУРУУН-2
ОРД (БАЯЖУУЛАХ, БОЛОВСРУУЛАХ
ҮЙЛДВЭР)-ЫН 2026 ОНЫ АШИГЛАЛТЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Ашигт малтмалын төрөл: ДАЙРГА

Үндсэн АТЗ-ийн дугаар: MV-016848

Хянасан : ХБОААХХ-ийн Дарга

/ Ж.БАТЗОЛБОО /

Боловсруулсан: Монфрукт ХХК-ийн ерөнхий инженер

/ Д.МӨНХЗУЛ /

2026 он



Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн
А/154 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДҮГНЭЛТ

Дугаар 0002135

Аж ахуйн нэгж, байгууллагын нэр: Монголрукт, ХХК
Хаяг: СХД-ийн 33-р хороо, Баруун түүшүүр-1
Ажлын байрны зориулалт, үйл ажиллагааны чиглэл: Завбрийн Ш.Т.С
153-ийн 10-н Завбрийн Ш.Т.С станц

Барилга байгууламжид гал унтраах тоног төхөөрөмж, /гал унтраах автомат болон
дохиоллын систем, утаа зайлуулах систем, усан хангамж/ анхан шатны багаж хэрэгсэл,
бодис материал зэргийг байрлуулан ашиглахад энэхүү дүгнэлтийг олгоно.
Галын аюулгүй байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3. 19 дүгээр зүйлийн 19.2/

Олгосон: 2023 он 03 сар 09 өдөр

Хүчинтэй хугацаа: 2023 он 06 сар 09 өдөр хүртэл

Дүгнэлт олгосон:

СХД-ийн Хурандаа дарга аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/
цолтой: А.Атангуйх

Дүгнэлт гаргасан:

СХД-ийн Ахмад дарга аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/
Гал түймрийн улсын хяналтын байцаагч: Т.Золжсайхан цолтой

Т.Золжсайхан
/гэмдэг дарна



Шалгалт хийсэн тухай тэмдэглэл

№	ШАЛГАХ ЧИГЛЭЛ	ХАМРАХ ХҮРЭЭ	ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН	СТАНДАРТ ДҮРЭМ НОРМЫН ШААРДЛАГА	ШААРДЛАГА ХАНГАСАН ЭСЭХ
1.	Барилга байгууламжид байгаа гал унтраах болон галаас сэргийлэх тоног төхөөрөмж	Гал унтраах автомат тоног төхөөрөмж	.		
		Галын дохиололын систем			
		Утаа зайлуулах систем			
		Аврах хэрэгсэл			
2.	Гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл	Гал унтраагуур			
		Галын саравч			
		Бусад			
3.	Галаас хамгаалах болон гал унтраах бодис материал	Гал унтраах усан хангамж			
		Гал унтраах хөөс			
		Галаас хамгаалах түрхлэг/ нэвчилгээ			
4.	Бусад	Авралтын зам гарцын тэмдэг, тэмдэглэгээ			
		Бусад			

Шалгасан:

Гал түймрийн улсын хяналтын байцаагч

Цолтой

БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ЗАРДАЛЫН 50% -ИЙГ
БАЙРШУУЛСАН БАРИМТ /6 САЯ ТӨГРӨГ/.

[Гүйлгээ >>](#) **Банк хооронд**

Таны гүйлгээ амжилттай хийгдлээ

ЦАХИМ ГҮЙЛГЭЭНИЙ БАРИМТ

ШИЛЖҮҮЛЭГЧИЙН МЭДЭЭЛЭЛ:		ХҮЛЭЭН АВАГЧИЙН МЭДЭЭЛЭЛ:	
Банк:	ХасБанк	Банк:	Төрийн сан
Данс:	5003847727	Данс:	100900013406
Нэр:	МОНФРУКТ ХХК	Нэр:	БО нөхөн сэргээх баталгаа
Дүн:	5,000,000.00	Дүн:	5,000,000.00
Валют:	MNT		

Гүйлгээний мэдээлэл:

Гүйлгээний дугаар: **000238700529** Гүйлгээний шимтгэл: **200.00 MNT**
Гүйлгээний утга: **БОМТ-ний барьцаа төлбөр РД: 2678586**
Гүйлгээний хүсэлт илгээсэн: Гүйлгээ баталсан: **monfrukt**

Гүйлгээ хийсэн огноо: **2026-03-18**

Энэхүү цахим гүйлгээний баримтыг засварлах, Мэдээлэл өөрчлөх болон аливаа хууль бус зорилгоор ашиглахыг хориглоно.

[Гүйлгээ >>](#) **Банк хооронд**

Таны гүйлгээ амжилттай хийгдлээ

ЦАХИМ ГҮЙЛГЭЭНИЙ БАРИМТ

ШИЛЖҮҮЛЭГЧИЙН МЭДЭЭЛЭЛ:		ХҮЛЭЭН АВАГЧИЙН МЭДЭЭЛЭЛ:	
Банк:	ХасБанк	Банк:	Төрийн сан
Данс:	5003847727	Данс:	100900013406
Нэр:	МОНФРУКТ ХХК	Нэр:	БО нөхөн сэргээх баталгаа
Дүн:	1,000,000.00	Дүн:	1,000,000.00
Валют:	MNT		

Гүйлгээний мэдээлэл:

Гүйлгээний дугаар: **000238710337** Гүйлгээний шимтгэл: **200.00 MNT**
Гүйлгээний утга: **БОМТ-ний барьцаа төлбөр РД: 2678586**
Гүйлгээний хүсэлт илгээсэн: Гүйлгээ баталсан: **monfrukt**

Гүйлгээ хийсэн огноо: **2026-03-18**

Энэхүү цахим гүйлгээний баримтыг засварлах, Мэдээлэл өөрчлөх болон аливаа хууль бус зорилгоор ашиглахыг хориглоно.